

Иш Сурэнжав

САМУРЫ
САМУРЫ
САМУРЫ
САМУРЫ
САМУРЫ

Ш.Сүрэнжав

ЧАДАХ
САМУК



Ш. Сүрэнжав

УУЛЫН САЛХИ *(Туужсууд)*

“Монголын зохиолчдын хороо” Улаанбаатар хотноо 1968 онд эрхлэн
хэвлүүлсэн номоос

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар Цагаан бамбарууш хэвлэлийн
газарт 2021 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: www.e-nom.mn

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.

The banner features a green border and a dark blue background. At the top left is a logo with a stylized 'B' and a checkmark. Below it, the text reads 'БОЛОР ДУРАН 2.0' and 'АЛДА ШАГЧУУР'. In the center, the title '“БОЛОР ДУРАН” ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ ПРОГРАМ' is displayed. To the left is a cartoon boy pointing right, and to the right is a cartoon girl. A list of four benefits is shown with green checkmarks: '60 сая үгийн сантай.', 'Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.', 'Хэлзүйн тайлбар тольтой.', and 'Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.' Below the text are images of two software boxes ('Болор дуран 2.0' and 'Болор дуран 2.0') and a computer monitor displaying the program's interface.

Агуу их Октябрын хувьсгал болон эх орны их дайнд оролцож явсан Монгол хүмүүс; Юндунов хэмээх Лодой, гутлын үйлдвэрийн тэргүүний ажилчин Ширзана нар болон түүний дайчин нөхөд хийгээд Зөвлөлт Монголын ард түмний эвдэришгүй найрамдлын үйлсэнд энэ номыг зориулав.

ЗОХИОГЧ
1967-11-7

ОДНЫ ГЭГЭЭ

Тэнгэрийн алтан гадасны
Тэр зүгт бас
Газрын алтан гадас
Гал адил гэрэлтэж байна.

1944 оны намар цаг сан. Дэлхийн дайны түймэр дарагдах тийшээ хандаж, зөвхөн халуун нурам нь бургиж байсан ўе! Би тэр цагт цэргийн бага тушаалын даргын үүргийг хүлээж явжээ. Биднийг суулгасан ногоон онгоц улам улмаар доошлон бууж эхлэв. Дээр явахад тэнгэрийн хаяа цэлийгээд талын зах алдран нил цэнхэр шилэн дор байгаа мэт униартан байснаа доошлох бүр юмын бараа ойртон тодорч томорсоор, газар эрээн даавуу шиг эрээлжлээд удалгүй онгоцны дугуй түрр хийн газардаж хэсэг гүйгээд жолоо татан зогслоо!

Өмнөөс эрүүл агаар сэн хийж дотор уужраад хэзээний танил «Цагаан олом»-ын орчим байгаль нүдэнд тусав.

Нутгийн улс доорхноо бүчин авч хүүхдүүд ар өврөөр гүйлдэн зарим нь холоос цэрвүүхнээр онгоцны доогуур сонирхсон, айсан холилдмол харцаар шагайж ч үзэгдэнэ.

Дотоод яамны хязгаарын газрын дарга, бага зэрэг буурал орж яваа цулдамхан чийрэг хурандаагийн араас дагалдан гарсан зөвлөлтийн мэргэжилтэн сургагч, дэслэгч генерал Попов гуай тэдгээр хүмүүс дундуур тамхia зугуухнаар сорон явж байснаа гэнэт,

— Чи чинь ингэхэд Юндунов мөн байна уу гэж дуу алдах нь сонсогдоход бид цөм эргэж харлаа.

Гэтэл нэлээд хир суусан хүрэн даалимбан дээлтэй янхигар өвгөн,

— Тийм ээ, би байна. Та чинь Петя мөн шив дээ хэмээн хариу тавьсны хойно нөгөө хоёр чинь мэнд сайнаа мэдэлцэж тэр ч байтугай тэврэлдээд авдаг байна шүү.

За энэ золиг шиг хөгшин яаж халаадаг бол? гэхээс бид хэдийн яс хавталзаж, дэмий л гайхширан байтал генералын гараас дугтран тэвэрч үнсэлдээд энэ ханхийсан өвгөний хаанаас гарав аа? гэмээр цэвэрхэн нь аргагүй орос хэлээр урсгаж гаражад нь бүүр цэл гайхаж хоцроод нэг л их алмайран амаа ангайсан амьтад болоод зогсож байв аа чи минь. Үгүй ер нь гайхалгүй ч яах вэ дээ! Одоо генералд Юндунов гэж дуудуулаад сүйд болж байгаа энэ өвгөнийг би урьд нь

сайн таних юм чинь. Миний л мэдэхийн ойрын хэдэн жил энэ голын хөвөөнөөс салаагүй гүүрний манаач хийж нэг ёсондоо нааш цаашаа явдаг улсын дэн буудал болсон юм л даа. Дөрвөн ханатай божгоор бор гэрийнх нь босгоор эзэн хүн шиг алхаж, хатавчинд нь эмээл хазаараа хаячхаад, зүүн талын навтгар модон орон дээр нь хажуулдасхийж өвгөний буцалгасан хар цайнд боорцог хөвүүлж, заримдаа царцсан мах хөшиглөж идээд гол орж, бас ч юмтай яваа үедээ богцноосоо шил юм гаргахад өвгөн хуваалцахаасаа татгалздаггүй сэн! Тэхдээ мань хашрыг ер Юндунов гэдэг нэртэй юм гэж дуулаа ч үгүйн дээр Лодой гуай гэлцэн заримдаа Лодой гээд ч дууддаг байлаа.

Гэтэл одоо Юндунов гэхлээр буриад ч юм уу нэг л өөр ястан хүн шиг санагдана. Бас тэр оросоор ярьж байгаа нь ч гэсэн дээ!

Гэтэл урьд нь яг л цэвэр халх хүн шиг санагддаг байсан юм. Үгүй ээ ингэхэд энэ өвгөн ингэж шид ургасан юм шиг орос хэлтэй болчих гэж дээ!

Энэ чинь нөгөө ямар ч билээ дээ нэг их ном зохиосон эртний Энэтхэгийн Галийдаас гэдэг шиг нэг шөнө шид ороод ертөнцийн бүх юмыг мэддэг болчихмооргүй л юм даа. Харин инээд хүрэв байна. Нээрээ хачин золигоо. Бидний, оросоор мэддэг хэдэн хараал ерөөлөө хазгай мурий хэлж байхад мань өвгөн дэмий л мушилзаж байдаг сан. Тэгсэн хэр нь өөрөө юу ч мэддэггүй юм шиг л царай гаргаад байдаг. Хий гаргадаггүй гүзээ шиг, сэтгэлээ хав дардаг айхавтар эд байж л дээ. Тэхдээ лав биднийг битүүхэн шоолж байсан хэрэг байна шүү.

... Бодолдоо болоод нөгөөдүүлийн яриаг ч сайн анзаарсангүй. Нэг мэдэх нь генерал маань гэрт нь очихоор явж байлаа. Өвгөн урьсан юм санж. За бас яаж халаадаг юм бол доо! Гэрийн дотор дэвссэн адасга, навтгар модон орон дээрх хураалттай дээл, уг нь ямар будагтай байсан нь мэдэгдэхээ больсон хэдэн авдар, үнсэнд шургуулсан зэс домботой цай нь үзэгдэх болоод өвгөний төлөөнөөс зовж орхилоо.

Бид бол ч ямар хамаа байх вэ? Гэтэл гаднын хүн, тэр дундаа ийм том хүний нүдэнд бол юу гэгч болдог болоо? За байз мань Лодой чинь үгүй ээ Юндунов чинь... За за яршиг хуучнаараа л нэрлэе! Тогтоогдох ч үгүй юм. Мань Лодой чинь бурхантай бил үү? Ер санаанд орохгүй байна. Бурхан бий билүү үгүй билүү. Лав л Будённый нэг, морь унасан зураг санаанд тодхон байна. Өөр бас нэг танихгүй орос цэргийн даргын зураг байсан Ленинийх билүү. Сталиных билүү за байз алиных

нь билээ. Нэг зураг лав байсан гэж дотроо хуруу даран орж гарсан хэрэгтэй хэрэггүй юм бодсоор гэрт нь хүрлээ.

— ... Үгүй хөөе! санаснаас овоо гээч! шар гуулиар бөгжилсөн зэс домбо нь элсээр зүлгүүлсэн юм шиг өнгө орон гялалзаж, авдар сав нь хүртэл шороо тоосгүй, овоо л доо! Ээ харлаа! унинаас татсан хэц дээгүүр тохож тавьсан нүүр гарын алчуур нь өвгөний нүүр шиг пад харлаад... ядахдаа ил байдаг нь ч юу ч вэ дээ. Өөрөө угаадаггүй юм гэхэд яагаа вэ дээ нөгөө хэн билээ. Тэр хөгшинөөрөө угаалгачихгүй. Бөөн цагаан гэж нэрлэдэг (бодвол хоч нь л байх) нэг тарган хөгшин энэ хоёрыг сүрхий юм гэж эндэхийнхний авгай хүүхнүүд шивэр авир гэдэг байсан юм. Тэр нь энүүхэн хойд энгэрт бас нэг жижгэвтэр гэрт ганцаараа шахуу байдаг бөгөөд,

— Энэ хоёр ингэж өөд сөөргөө явснаас хоёулаа нэг гэртээ орчихгүй дээ. Тэгвэл ядахдаа хоёр давхар бүрээстэй болоод аштай дулаан байх уу даа гэж зарим нь өрөвдөж байгаа дооглож байгаа хоёрын аль нь үл мэдэгдэх байдлаар өгүүлдэг байсан юм.

... За ингээд генерал тэр хоёр ярилцаж эхэлдэг байна. Өвгөн ч нэлээд ам халжээ (таваг тариа, идээ будааг бол хэдийн тавьсан хэрэг. Түүгээр ч барахгүй мань өвгөн нэг галуун хүзүүт нэрмэл гаргаж хариуд нь генерал бас хувиа гаргаж өгсөн юм).

— Юндунов чи одоо энэ жил хэд хүрч байна вэ?

— За байз би чинь манжийн бадаргуулт төрийн 20-р он, хөх морин жил төрсөн... Тэхлээр чинь байз, энэ жил яг зуугийн хагас нас сүүдэр зооглох нь дээ.

— Тавин насны ойгоо хэзээ хийх вэ?

— Манай энд ч наян тавны найр л гэж хууччуул ярихаас тавин насных гэж нэг их арвитай юм дуулддаггүй юм даа. Аа харин та хэд хүрч байна.

— Би 1891 онд төрсөн. Энэ жил 53-тай өөрөөс чинь гурав ах юм даа.

— Тэгнээ тэр. Петя чи намайг Бооржийн (Борзя) өртөөн дээр дайралдахдаа зодчиоод байдаг байсан юм. Хоёр ах хүн чинь аргагүй шүү дээ. Тэхэд чинь би дөнгөж 15-тай шалчгар хүү байлаа. Тэхэд чи бараг цэрэгт мордох шахсан хүн байж шүү дээ.

— Цэрэг гэснээс чи бид хоёр мөн наргиж байж билээ. Чи санаж байна уу? Өвлийн ордыг эзэлсний дараа чи штабт дуудагдаад яаж явлаа. Тэгээд бид орой нь чиний тушаал дэвшсэний баяр болгож жаал

юм балгаж бас зургаа авхуулж билээ. Өвгөн нэг юм санаанд нь орсон бололтой гэнэт босоод авдраа уудалж эхлэв.

За мань Юндэн юу гээгчийн нарийн нандин юм гаргах нь вэ гээд харж байтал даллагын сав шиг хадагт ороолттой хэсэг юман дотроос ухаж ухаж нэг зураг гаргаад ирдэг байна. Он жилийн урсгалд бага зэрэг шарласан боловч аргитай хадгалснаар дүрс нь төдий л муудаагүй зургийн цаасан дундаас залуухан дэслэгч Юндэн, Петя хоёр мөрөө түшилцэн мишээнэ. Цаагуур нь Нева мөрөн мэлтийж, алс эрэгт нь цайзын хана, мөрний эргийн шувуун завьт багана, гүүрний хэсэг тэргүүтэн үзэгдэнэ. Ар талыг нь эргүүлж үзвэл: 1917 оны 11 дүгээр сарын 10. Петроград гэжээ.

— Петроград одоо их өөр болоо биз дээ? хэмээн Юндэн ихэд сэтгэл хөдлөн өгүүлээд идэр залуугийн явдал, Нева мөрний тунгалаг долгио тэргүүтнийг санагалзсан мэт нөхрөө харна.

— Тийм ээ. Ленинград тун сайхан хот болсон шүү. Харин саяны дайнд германчууд их сүйтгэсэн дээ. 900 хоногийн бүслэлтийг зоригтай давсан, 470 мянгаад хүний амь хохирсон гэж хэлээд, генералыг дуугүй болоход дайн дажны аюул хүн бүхний дотор орж ирээд нэг хэсэг чимээгүй болцгоолоо.

Манайд ч гэсэн дорнод хилээс япон удаа дараа өнгөлзөж байгаагийн дээр бид хэд ч гэсэн энэ удаа баруун хилийг тохинуулахаар яваа билээ. Учир нь Османы дээрэмчид сүүлийн үед хилээр, ил далд орж ирэх нь ихсээд байгаа юм.

Чимээгүй... байдлыг эвдсэн генералын дуу дахин сонстож,

— За нөхөд минь юунд чимээгүй болчихоо вэ. Урьд урьдахаа өргөцгөө! Манай ард түмэн, эх орны агуу их дайнд ялагчаар алдаршиж байна. Удахгүй рейхстаг дээр тут хатгахын төлөө! гэж цог жавхлантай хэлээд өөрөө биеэр үлгэрлэх мэт хундагаа хөнтөрчхөв.

— Юндунов чи тэгээд хэр зэрэг амьдарч байна даа.

— Яах вэ зүгээр сайхан л амьдарч байна.

— Чи нөхөр Чойбалсантай уулзсан уу?

— Үгүй ээ, үгүй. Би юу боллоо гэж маршалтай уулзах билээ дээ?

— Чи чинь Октябрьн хувьсгалд оролцсон хүн шүү дээ.

Оролцооор ч барахгүй тэр хувьсгалыг хийлцэж, өвлийн ордонд хүртэл дайран орж явсан зоригтой эр байхгүй юу?

— Ай зайлзуул! Миний зоригтой ч дээ.

— Яагаад тэр билээ? Тэр ч байтугай чи партизан хүн шүү. Чи Щетинкиний ангитай явсан шүү дээ. Тэхлээр ардын хувьсгалд оролцоо биз дээ.

— Оролцох ч оролцсон л доо.

— Тэгээд,

— Тэгээд яах вэ дээ. Ингээд болж бүтээд сайн сайхан л явж байна.

— Чиний партизаны үнэмлэх чинь хаана байна.

— Хаана ч үгүй.

— Яагаад,

— Яагаад гэж үү! Яагаад гэхлээр ярих юм их гарна даа. Би ерөөсөө партизаны үнэмлэх аваагүй юм.

— Татгалзсан хэрэг үү.

— Тэгээ ч үгүй л дээ.

— Тэгээд,

— Тэгээд л тэр дээ. Петя минь одоо түүнийг яриад юу хийх вэ.

— Яагаад тэр билээ нөхөр минь. Чи ерөөсөө өөрийнхөө явдлыг хэнд ч яриагүй юм уу.

— Тийм ээ. Хэнд ч хэлээгүй. Хэн намайг итгэх юм бэ?

— Чи тийм итгэлгүй юм хийсэн хүн үү?

— Үгүй ээ

— Жишээ нь би чамайг яагаад гэрчилж чаддаггүй билээ.

— Чамтай чинь хорин долоон жил өнгөрсний хойно дөнгөж өнөөдөр л уулзаж байна шүү дээ.

— Тийм ээ нээрэн тэр цагаас хойш олон жил өнгөрч шүү. Генерал хуучин танилаа сэтгэл уярсан байдалтай ширтэж тамхиа асаагаад нэг юм хэлэхээр завдтал гаднаас нэг байлдагч орж ирээд онгоц нисэхэд бэлэн болсныг илтгэсэн тул бид цөм яаран босоцгоов. Генерал маань Юндэнг сайн нөхрийн ёсоор тэвэрч аваад,

— За баяртай шонхор минь, удахгүй Улаанбаатарт учрахын ерөөл тавья гэлээ. Өвгөний сэтгэл ихэд догдолж буй нь илт авч миний хот орох ч дээ гэсэн янзтай өөртөө инээмсэглэн,

— Сайн яваарай Петя минь сайн яваарай! гэж байн байн хэлээд онгоц далд орон ортол гаднаа зогссоор улдэж билээ.

* * *

Түүнээс хойш хоёр жил өнгөрсний хойно миний бие албаны ажил, амины сонирхол хоёрыг хослуулан «Цагаан олом» орж билээ. Энэ үе

дэлхийн хоёрдугаар дайн Зөвлөлтийн ард түмний гайхамшигт ялалтаар төгсгөл болж зүүн зүг япон ялагдаад тэр бүхний гэрч мэт миний энгэрт хүртэл «Бид ялав» хэмээх алтан медаль гялалзаж байлаа. Би өвгөнийд хоног тааруулж очлоо. Бид хоёр тэр шөнө бараг нүд аньсангүй тус тусын ор дэр засаж авсны дараа дэрэн дээрээ тохойлдон өндийж тамхia дөхүүлж аваад:

- За өвгөн минь яриад байгаарай гэсэнд,
- Юунаас нь эхэлж ярьдаг билээ дээ? гээд хэсэг бодолхийлснээ өгүүлрүүн,
- За хөө чи сонсож бай! Манжийн төр мөхөхөөс хоёр жилийн өмнө хэвт ёстын нэгдүгээр оны (1909) намар цаг асан! ... Чи Галын гурван шил, сэвсүүлийн говь дуулсан уу!
- Дуулсан юм байна.
- За тэгвэл тэнд чинь нэг банди гав ганцаар гүйж явжээ гээд үлгэр шиг уянгалуулан эхэлснээ,
- Тэр нь би байсан юм гэж огцомхон байдлаар төгсгөөд яриагаа түр завсарлаж тамхia нэрлээ. Утааг нь ховдоглон сороход ам хамраар нь хятад дүнсний утаа савсаж гарлаа. Өвгөн миний асуугаагүй байтал,
- Энэ дүнсэн тамхийг манай эндэхийн нэг хархүү өнгөрсөн жил дайнаас буцаж ирэхдээ авчирч өгсөн юм гэснээ,
- Манайхан чинь бараг түмэн газрын цагаан хэрэм гээгчийг хүрсэн юм даг уу даа! Харин илүү дутуу юм авбал ч толгойгүй болж байсан юм биз дээ гэхэд би дуугүйхэн дохилоо.
- Үгүй ээ тэгээд зарим залтайхан шиг нь юухан хээхэн нуугаад аваад ирсэн л байх юм даа. Баян Балжирын хүү Наваан хоёр ч хулсан ташууртай буцаж ирсэн сураг дуулдана билээ гээд өвгөн цааш ярих гэхэд нь би тэсэлгүй үгийг нь тасалж,
- За тэгээд Галын гурван шилд нэг банди гүйж явсан. Тэгээд юу болоо бол! гэсэнд Юндэн маань тамхia нэг сайн сорж аваад гансныхаа үнсийг өмнөх суумал ширээний өнцөг дээр цохиж унагаад,
- Тэгээд үү! Тэр хэрэг анх ингэж эхэлсэн юм. Манай эцэг нэг өдөр намайг шарга мориндоо сундлаад хүрээ хийдэд хүргэж өгсөн юм. Би уг нь хар болох санаа их байлаа л даа. Нэг муу мод толгой төхөөрч аваад дээлээ хүлхийлгэн хөөргөж бүслээд, ардаа аав шигээ том хутга хавчуулаад дайралдсан амьтантай арилжаа наймаа хэлэлцэж эсвэл,
- Зөв талынхaa гуя дээр чандмань тамгатай шар хээр морь, ланз тамгатай бор үрээ, асман хар азарган үрээтэй долоо найман адуу

үзэгдэх юм юу байна гэхчлэн эрэл сурал болж хярын толгой хэсэн айл амьтнаар орж гарч явдаг нутгийнхаа харчуулын адил тийм л эр болох сон гэж боддог байсан юм. Тэгээд ч хийдэд очсоныхоо дараа нэг удаа оргоод харьчихсан юм. Гэтэл манай аавыг чи ямар хүн байсан гэж санана. Юм л бол лам гурван эрдэнэ гэж залбирсан, сүжиг бишрэл гэж сүрхий жигтэйхэн. Ямар сайндаа энэ хэдэн малын захтай яваа чинь аав ээж, ачит лам гурван эрдэнийн буян гэж үглэн жил өнжихгүй шахам жасаагаа уншуулж даллага авхуулдаг байлаа. Тэгээд намайг гүйгээд очиход нүүр өгөлгүй Содном гавжид хүргэхэд хонгоноос маань хорстол ухаж хоёр хадны хооронд хавчуулагд сан төмсний цэцэг шиг амьтан болголоо.

Манай хүрээнд хүрэн дээлт Чой банди гэж нэг их дүрсгүй гайхал байх л даа. Би ч хувияа тавихгүй өнөөхтэй чинь нийлж аваад үймнэ.

*«Ходоодон жса, хоёр гэдэстэй ча
Бөгтөр да, бүстэй та
Эргүүлсэн на,
Эцгийн «па» эхийн «ма»»*

гээд л хэлбэр дүрсээр нь нэрлээд аюулын нь аргагүй тангад ном үзэж байтал өнөөх хүрэн дээлт Чой банди энд тэндээс исгэрч дуудаад эхлэхтэй зэрэг сэтгэл хулжиж гараад өгдөг сөн. Дорхноо л банди нартай бужигнаж,

*— Еэ еэ бөө бөө
Гүйгээд ирэхийн
Гүзээ байна уу.
Дайраад ирэхийн
Давсан байна уу?*

гэж хашхиралдаад шинэ ирсэн банди нарыг өдөж,

*Хөдөөгийн хөөсөн мантуу
Хөвөн жинтуу*

гэж дуудан занgidсан сайртай гараа үзүүлж,

*— Чи уүнийг
Хүний гар гэж бодно уу?*

*Хүрээний хүрэн хар
Лантуу гэж бодно уу*

хэмээн сүрдүүлж явдаг өнөө сүрхий хүн чинь, багш ламын гарын шүүр үзэхээрээ өнөөх түмэн омог нь шалчийгаад хий нь гарчихсан гүзээ шиг болж дэний л байя, байя багшаа. Ахиад тэхгүй гэж толгойгоо дарж орилдог сон. Нэг мэдэх нь нөгөө хүрэн дээлт Чой банди маань оргочихсон дуулдана. Гэртээ ч хариагүй сурагтай. Арай чоно нохойд бариулчихсан юм биш байгаа гэх аймшиг төрөхийн зэрэг бас оргомоор санагдана. Гэтэл эцгийн царай сэтгэлд харагдах шиг болоод бас л буцаагаад ирэх биз гэхээс хонгоны мах аандaa хорсох шиг болно. Иймэрхүү янзтай хоёр жил болоход би 15 нас хүрч овоо чадал суусан юм шиг санагдах болсон байлаа. Энэ хооронд хэчинээн зовсон гэж бодно. Хар цай, хатсан дугуйгаар гол зогоож, хөдлөх бүр хэмжээтэй, зөрчих бүр зодууртай, хог шороо цэвэрлэж нэргүй зарц болж явлаа. Нэг өдөр багш ламын эзгүйд олбогт суудал дээр нь шанам малгайг нь духдуулан суугаад, шаазан хөөрөг атган тамхилж, хонх дамрыг нь дуугарган, бурхны зүг үе үе хялалзан, санаандаа орсон ном уншиж байлаа.

*Марми пулбий содиом жий
Шийрав марми ёртовной
Мажир санжаан тамжид жи
Бумбын думаа сэлбэр шоог!*

гээд зулын ерөөл эхэлснээ,

*«Дамбий манлай римби дэнду
Чансул ваани нису зажси»*

гээд лхам, дархи хоёрыг хооронд нь холиод хүртэл санаандаа орсныг тууж байхыг мэддэг хүн харсан бол лав намайг солиорч гэх сэн. Тийн ламын дүрд итгэл орж эсэн бусыг дуурайн үйлдсээр байтал өдөр өнгөрч багшийн ирэх цаг ойртооныг мэдмэгц сандран босож, хөөрөг юмыг байранд нь тавиад зуухны аманд яaran тонгойж галлаж эхэллээ.

Утаа уугиад нэг л олигтой асаж өгөхгүйд өвдөг дээрээ сөхөрч суугаад үлээж гаргал гэнэт гал дүр хийн ноцож, толгойтой үс шархийх шиг болоход сэхээ авч үзвэл толгойдоо өмссөн шанам малгайг авч

тавихыг мартсан байх бөгөөд хэсэг газраа хийхлагдсаныг үзээд баларчээ гэх бодол зурсхийж дотор палхийв. Төд удалгүй багш лам ирлээ. Их л сайхан зантай байна. Шөнө нь миний нойр ер хүрэхгүй эргэж хөрвөж хэвтэхэд лам багш маань зүүдлэн яраглаж ямар нэгэн юмыг гуйн хүсэж байгаа мэт сэтгэгдэнэ. Бас Чанцалдулмаа гэж байн байн дуудахад нь үе үе мөргөхөөр ирдэг нэг ганган авгайн сайхан царай санаанд орно. Ингэж байсаар сүүлдээ нам унтаж орхижээ. Өглөө нар ханын элгэнд буух үеэр багш хуралдаа явах боллоо. За одоо юу гээч болдог бол? гээд зүрх шимширч байтал мөнөөхөн хийхлагдсан малгайг олж үзээд юу юугүй л шуугиад орж ирлээ. Би байя. Багшаа байя байя гэж хашхирад ар тийшээ унаад өглөө.

Ойртоод ирэхтэй нь зэрэг атийж байсан хөлөө санаандгүй тийрч орхитол багш ламын элгэн дээр хэг хийтэл тусаад гэдрэгээ савж унахдаа дагзаараа яг хийтэл хана мөргөж байгаа харагдав. Тэр хооронд би амжин гарч зугтаалаа. Араас минь тэсэртлээ уурлаж галзууртлаа хорссон ламын дуу чихнээ хадаж, ална даа чамайг гэж аймшигтайгаар архиран занан байх нь сонсогдлоо. Гүйн гүйсээр хэдэн гудамж хөндлөн сүлжиж хийдийн захад гараад хогийн цаагуур нуугдан гүйсээр жалга дамжин гүвээн дээр гараад эргэж үзвэл хойноос нэхсэн хүн үгүйд түр зуур сэтгэл амраад цааш жирийлгэж өглөө. Өдөр дундын хийдээс нэлээд алсалж ээрэм тал дунд гүйж явлаа. Эргэн тойрон царцаа царгиж, талын эгшиг чихэнд хангинаад тэнгэр хязгааргүй мэлтийнэ. Түр зуур дээшээ харж хэвтэхэд цагаан цагаан үүл үе үе нүүдэллэнэ. Түүний цаанаа үүргэлшгүй цэнхэр тэнгэр хөхрөн цаашилж толгой эргэм санагдана.

Хээрийн амьсгал юутай ч зүйрлэшгүй сайхнаа! Насаараа энд бүүвэйлэгдэн хэвтмээр санагдана. Өвсний үнэр ийм сайхныг би урьд нь мэддэггүй байжээ.

Хамар цоргин анхилах агь гангын үнэр, хүрээ хийдийн үхмэл чийг хэншүү хярvasыг сэтгэлээс огооруулж, чөлөөт амьдралын шинэ сонин бодлыг зүрхэнд төрүүллээ. Үсрэн босоод цааш явах зуураа ийн бодлоо.

*Адуунаасаа салсан унага, чонын хүнс,
Айлаасаа төөрсөн хүн, хээрийн хүнс*

Гэж ээж минь хэлдэг сэн. Булгарсан чулуу буцаад байрандаа багтдаггүй шиг эргэж очих нь лав өнгөрлөө.

Гэртээ харина гэхээс бас л зүрх өвдөн халширна.

Манай энэ хонхорт л лав шашин бурхандаа тэрсэлж лам багшаа өшиглөж зодсон хүн байхгүй гээд л аав сүйд болно гэж бодохоос тогоо доргин хангинах дуу нь чихэнд хадах шиг болоод хүйтэн хөлс дааварлана.

Яалтай юм билээ! хэмээн бодлогоширсоор хэчнээн явснаа ч мэдсэнгүй. Анзаарч үзвэл бараг өртөө шахам явсан бололтой. Уулын сүүдэр уртсан уртассаар нар хэдийн шингээд, оройн сэргүү орж салхи сэргигнээд тэнгэрийн хаяанд цахилгаан цахиж үзэгдэнэ. Шөнө боллоо. Эргэн тойрон тогоо хөмөрсөн юм шиг харанхуйлж бут харгана хүртэл уул овоо шиг харагдан айдас төрүүлнэ.

Нэгэн харганын өвөрт цөмцийн сууж үүр цайхыг хүлээхээс аргагүй болов. Шөнө дундын хирд дуу цахилгаантай бороо шаагин орлоо. Тэнгэр нижигнээж хуурай цахилгаан цахилах нь газраас ховх сорчихоо алдах мэт сэтгэгдээд ойртон ирэх аадрын чимээ нэн аймшигтай. Нүцгэн талд харж хамгаалах юмгүй хоцроод өнчин бутны ёроолд хоргодсон намайг шалав арчин авах гэсэн мэх шуугин шаагин ойртоод удалгүй нүүр нүдгүй ташуурдаж эхлэв. Тэнгэр толгой дээгүүр тасхийн нижигнээд аянгын sumaар намайг эрэх мэт цахилгаан зурс зурсхийн гал бутраад түүний гэрэлд нил цайвар дэлхий хөвсөлзөн хөдлөх мэт үзэгдэхэд айдас төрж дэмий л,

*Ум даарий дудаарий дүүрий суухай,
Ум даарий дудаарий дүүрий суухай*

гэж үглэн элэг рүүгээ тарнидавч нэмэргүй, урьдахаас нэтрэх мэт бүр ч сүртэй тажигнана. Энэ бүхэн мөнөөхөн багш ламын хилэгнэл шиг сэтгэлд санагдахад элдвийг эргэцүүлэн гэмшиж суусаар өвдгөө тэврэн зүүрмэглэжээ. Өглөө сэрэхэд бороо хэдийн арилаад өвсөн толгойд ус бөнжгөнөж, зүүн талын ухаа дээгүүр цагаан манан хөшиглөж түүний цаанаас нар мандаж харагдана. Удалгүй нар дээшлэн дээшилсээр газар дэлхийг өвч гийгүүлж эхлэхэд даарсан бие тавигдан өнгөрсөн шөнийн аймшиг арилж сэтгэл тайвшран энэ чигээрээ хaa ч хүрч болмоор санагдана.

Тэртээ алсын хөтлөөр нэгэн их хөлийн зам зурайж цааш алсалжээ. Бараг тэнгэрийн хаяаны доогуур шахам нэгэн хөсгийн цуваа жирийн, нөгөө замд дөтөлсөөр байгаа харагдана.

Дэргэд шувуу жиргэн, дээрээс нар халаан, салхи хaa ч нэг сэргигнээд намрын өвсний үнэр ханхалж голио царцаа тасралтгүй

царгина. Жин үдийн алдад мөнөөхөн хөсөг бид хоёул их замын хоёр талаас нийлэв. Цацагтай шовгор улаан малгай шилдсэн, ямаан хилэн дээлтэй тарган шар буриад хүн надтай их л элэгсгээр яриа дэлгэж Сан бэйсийн хүрээ орж арилжаа хийгээд буцаж явна хэмээн ярина. Уул хөсгийн хамт өдөржин явсаар орой нар жаргахын хирд нэгэн ундарга усны хажууд буудаллав. Тэндээ тарган махны шөлөнд цохиулан унтаад өглөө болж дахин ачаалж эхлэхэд нөгөө буриад хүн маань:

— Бид одоо зүүн хойш боорж орох тул зам салах нь байна. Гэвч чи нэгэнт буцах газаргүй болсон хүн тул надтай хамт явж орос буриад нутагт очиж самган бид хоёрын хүү болбол яана! гэсэнд би зөвшөөрөн толгой дохиж орхилоо. Бид яван явсаар оройхон хирд нэгэн даваан дээр гарлаа. Нутаг маань тэртээ ард цэнхэртэн харагдана. Нүдээр нулимс бүрхэж аав ээж минь санаанд оров. Тэгээд дэргэдэх улсаас нэрэлхэн гарын алгаар нулимсаа нуун арчиж орхиод сэтгэл хатуужин овооны чuluунд хэдэн чuluу авч хаялаа. Хөсөг давааны ар луу бууж эхлэв. Эргэн харж сэтгэлийн дотор уяран ёслоод толгой өндийлгөн өмнөх замаа харвал алс тэнгэрийн хаяанд хөх уулс зэрэглээд тэр зүг зорьсон урт зам зурайжээ.

Асрамждаа авсан шинэ эцэг маань намайг харж инээмсэглээд,

— Эр хүн их юм үзнэ! гэж хэлээд зүүн хойш тэнгэрийн хаяаны доогуур зааж,

Чита хот тэнд бий! Би чамайг сүүлд дагуулж хот үзүүлэмз гэлээ. Би толгой дохиод заасан зүгт нь харвал хаяа дэрлэн зээглэх хөх уулсын цаагуур цэнхэр тэнгэр хөмрөглөөд хэсэг цагаан үүл хөвсийсний доохнуур ямар нэгэн жигүүртэн далавчaa дэвэн нисэх нь үзэгдэв.

* * *

Тэр цагаас хойш таван жил өнгөрчээ. Үүнийг Петербургийн шуугиант гудамжаар явж байхдаа би бодож олсон юм. Би хэвт ёстын 1 дүгээр он, тахиа жил хийдээс оргосон. Одоо энэ европынхоор бол 1914 он болоод байна. Энэ хооронд миний амьдралд ч олон янзын учрал тохиол болж би эдүгээ хорин нас хүрчээ. Одоо би НЕВА-ийн гудамжаар баруун тийш явж байна. Харанхуй цонхтой том том бараан байшингууд хоёр талаар зээглэн, чuluун багана үелэн ярайж, тансаг хээ сийлбэр тэргүүтэн нь товоийн харагдана. Манан бүрхсэн гудамжны үзүүрт цамнан цорийж байгаа морьтой ноцолдон зуурч, эцэст нь эрхэндээ оруулан авсан чийрэг эрийн нүцгэн баримал бүхий гүүрээр

гарч явахдаа энэ бүхнийг эргэцүүлэн санасан юм. Морины сүрлэг баримал хараад монгол нутгаа шүүрс алдан дурссан хэрэг! Энд ийм морыт баримал хөшөө дурсгалууд элбэг дайралдана. Их Петр хааны зэс морь цоройлгосон хөшөө, Исакиевын бөмбөгөр оройт дуганы ойролцоо орших орос баатрын өвч хуягласан морыт хөшөө зэргийн дэргэдүүр би ажиггүй гарч сэтгэл түvdэггүй юм. Энэ бүхнийг харахад морь унасан монгол баатрын дүр тодрон сайн үйлс бүтээхээр уухайлан давхиж яваагаар сэтгэлд дүрслэгдэнэ. Нутгаас гарснаас хойш арвитай юм сонссонгүй. Харин эцэг Бадмаев маань манжийн төр мөхөж монголд өөрийн автономит төр гэгч тогтоож гэнэ хэмээн хэдэн жилийн өмнө Чита орохдоо сонсож ирснээ ярьж билээ.

Манайх энэхүү Петербург хотод нүүж ирээд З жилийн нүүр үзэж байна. Миний өргөмөл эцэг болох Бадмаев яггүй хөрөнгөтэй хүн боловч түүнийгээ эдлэх бие нь элж яваа хүн билээ. Угийн архаг хуучтай бөгөөд түүнээ эмчлүүлэх гэж Дарасун ч орж байж билээ!

Дарасуны рашааныг та нар үзсэн үү? Их сайхан газар шүү. Тэндхийн ой мод байгалийн сайхныг хэлээд яана. Эмчлүүлэхээр ирсэн түшмэд, худалдаачин болон алтны үйлдвэрийнхэнд зориулж 1811 онд анхны жижиг байшин босгосон. Нутгийн буриадууд эргэн тойронд нь гэр майхан, овоохой элдэв эсэн бусын юmtай ирж рашаанд ордог байсан. 1894 онд өргөжүүлж арав гаруй байшин барьсан юм гэж нэг хүнийг тайлбарлан ярихад нь тэр чинь миний төрсөн жилтэй таарч байна гэж би дотроо бодож байснаас одоо болтол энэ бүхэн сэтгэлд тогтоогджээ. Рашаанаас буцахдаа аав бид хоёр тэрэгний арал дээр сандайлан суучхаад хоолой нийлүүлэн,

*Хамба дээлийнхээ цаана
Ханцуйгүй цамцтай
Ханжаарт гутлынхаа цаана
Хамаргүй оймстай*

гэж нутгийн баян Ёлхнийг шоолон дуулж явж билээ. Би анх айлд хөвүүн болон дагалдаж ирээд яаж хөглөж байсан гэж санана. Очсон даруйхан нэг орой аав Бадма ээж Санжидмаа хоёр маань хөрш орос Иван гуайнд айлчлахаар явчихлаа. Миний нүд анилдаж нойр хүрээд болдоггүй. Бүхлээрээ жаал хажуулдах гэтэл ор дэр дэндүү цэмцгэрдээд болдоггүй. Надад таарамжтай юм юу байна гээд харж байтал галын өрөөнд манайхны хөдөөгийн модон ортой төстэй, нэг цагаан

даавуугаар бүтээсэн модон орорхуу том байна. Энэ дээр чинь хажуулдаг хэрэг гээд даавууг нь ярж хаячхаад гутал дээлтэйгээ хэвтээд өглөө. Нэг мэдсэн чинь,

— Бос, бос. Энэ чинь одоо яаж байгаа нь энэ вэ гээд л чангаагаад байна. Шөнө орой болсон бололтой. Нөгөө хоёр маань шоолсон бололтой инээлдээд байна. Учрыг нь ч сайн олсонгүй.

Хожим мэдэх нь гурил зуурч талх иsgэж барьдаг гурилын вандан дээр нь унчихсан байснаа мэдээд ичих инээх зэрэгцэж билээ. Манай шинэ эцэг эх угаас үр хүүхэдгүйн дээр сэтгэл уужуу, сайхан зантай улс байсан учир би удалгүй идээшиж, муу хүрэн дээлийнхээ оронд шаахай дээр костюм өмсөж; саравчтай малгай тавиад Борзя суурины орос буриад хөвүүдтэй шуугилдан гүйлдэж, загасчлан, заримдаа ой modoор тэнэж, галт тэргээр ойр зуур явах зэргээр нэг хоёр жил доорхноо өнгөрсөн юм.

Энэ хооронд Иван гуайн хүү шар толгойт Петя бид хоёр үлэмж дотно нөхөрлөсөн бөгөөд анх тэр бид хоёр зодолдож танилцсан юм. Уг хэрүүл модны давирхай булаалдсанаас үүссэн бөгөөд би хүрээнд сурсан лам зодооны дэг ёсоор ханцуй шамлан гар далайж дайрсан бөгөөд Петя айсан юм шиг хэд бултан дээш доош болом ухрахад нь бүр омогшин дайртал ганцхан дэлсээд намайг намалдаглачихсан юм. Дараа уулзахдаа бид хоёр эвлэж сүрхий найз болоод, барилдаж хүчээ үзэхдээ би түүнийг цус амтагдтал тархиар нь тонгорсон юм. Тэднийх жаахан ногооны газартай. Би түүнд нь туслалцаж Петятай хамт гүйсээр тариа тарих дөртэй болсон юм. Бид хоёр тэр хавийн газрыг гүйцээж заримдаа галт тэрэг өртөөн дээр зогсох үеэр цэргүүд дунд гүйж явдаг сан. Тэд хуруу шиг бүдүүн мохоор ороож, нүдээ ирмэн дурсгүйтэх буюу «Манжуурын толгод» гэдэг сэтгэл уярам аялгууг «Баяан» хэмээх олон давхраат арьсан хөгжимд оруулж хоёр хавтсыг нь нэг мөрнөөс нөгөө мөрөндөө тултал дэлгэн дуу гаргана. Эргүүлэгт худгаас ус авч яваа улаан алчуурт Валя хүүхнийг дуудан хашхиралдаж Петя бид хоёрыг цаад эгчийгээ дуудаад ир! гэхэд нь бид хоёр,

— Тэр чинь чиний эгч юм байлгүй бид хоёрынх л лав биш дэг гэлцэнэ. Тэхэд, нөгөө цэрэг исгэрч:

— Хараач хөөе! Тосгоны харчуул, хонгорыгоо харамлаж байна гэхэд нь ичих ч шиг болоод нэг тийшээ алга болдог сон. Манайхыг Петербург нүүх болоход Петя их л дургүй байж билээ.

Урьд шөнө нь бид хоёр тангараг өргөж хаана ч явсан нэгнээ мартахгүй гэж ам өгөөд, Би түүнд хүрээнээс зүүж явсан сахиусаа (тэр дотор нь эвхэж хийсэн зурマル бурхныг их шохоорхдог байсан юм) тэр надад бүснээс юм уу тэлээнээсээ зүүдэг арьсан хуйтай агнуурын хутгаа дурсгаж билээ.

Петербургт ирээд бид хоёр байнга захидаар харилцдаг байсан юм. Гэтэл Петя ноднин жил цэрэгт мордсоноос хойш нэг хэсэг сураг тасраад саявтар нэг захидал ирүүлснийг үзвэл дайн эхлээд тун хүнд байдалтай байгаагаа дурдсан байлаа. Энд ч гэсэн ялгаагүй. Хөл үймээн, зарлал түгшүүр их болжээ. Эцэг маань буриад нутагтаа буцахаар шийдэж намайг галт тэрэгний билет олуулахаар явуулсан нь энэ билээ. Би хэргээ бүтээгээд буцах замдаа энэ хотод цорын ганцхан байдаг бурхан Буддын сүмд орлоо. Орос сүмийн дотоод байдлаас онхи өөр, бурхан, тахил, хүж утлага, хөрөг чимэглэл бүхий энэ сүмийг хараад монгол нутаг маань санаанд орно. Өөрийн аав ээж өдийд юу бодож суудаг бол гэхийн дээр мөнөөхөн хүрээнээс оргосон Чой банди бас над шиг ингээд явдаггүй байгаа даа гэж бодохдоо орж гарагсдыг дэмий л харуулдахад нэгээхэн ч монгол хүн үл үзэгдэх бөгөөд буриад, халимаг байрын царайнууд харагдана. Энэ сүмийг Альшаагийн Дандар Лхаарамба буюу Агваанлхаарамба гээч анх босгоход нь аравнайлсан гэх бөгөөд тэр бээр «Мянган нарны гэрэл», «Хоолойн чимэг», сарны гэгээн гэрэл гэх олон ном судрыг бүтээсэн хүн гэж эцэг Бадмаев маань надад ярьсан бүлгээ. Би энэхүү өршөөнгүй сэтгэлт буянт өгөөмөр эцгийн ивээлээр газар үзэж олны дунд нүд тайлсны зэрэг орос хэл бичиг үзэж урьд үл мэдэх номын ертөнцийн үүд хаалгаар шагайсан билээ. Би Чита хотоор явахдаа хувьсгалч ардач үзэлтэй гэгдэн цөлөгдөн гинжлэгдэж байсан Чернышевский гэгч хүний тухай сонсож түүний хоригдож байсан сараалжит байшин, гинж дөнгө тэргүүтнийг нүдээр үзэж бас Декабрист хэмээх 12-р сарынхны хоригдож байсан ажлын газар, хоолны өрөө, Мөргөлийн сүм зэргийг үзсэн юм.

Молодения София Волконская родилась и умерла
1830-7-10.

гэсэн үсэг бүхий пайлуур булш бунхны хэрээс одоо ч сэтгэлд сэрийсээр байнам.

Орос японы дайны үед ажилчдын хөдөлгөөнд оролцсон улсыг буудсан ЧИТА-гийн баруун урдах өндөр толгод одоо ч нүдэнд

харагдах шиг болном. Тэнд Костюшка Григорьев тэргүүтэй олон сайн эрийг буудахад улаан цамцтай тэрхүү чийрэг эр хилэгнэн хашхирч, ард түмнийг яргалж барахгүй гэхэд нь буудаж байсан хүмүүсийн гар чичирч байсан юм гэж хуучин ажилчид ярьдаг нь санаанд орном. Тэндээс Чита хот алган дээр тавьсан юм шиг ил харагдах бөгөөд шөрмөслөг гарын судас шиг салаалан сүлжсэн замаар нь утааг вагоны толгой уухилан гууглаад, мурий давчуу гудамж хашаа, тас хар дээвэрт модон байшингийн завсраар ноосон алчуурт хүүхнүүд хaa нэг өнгөрөхөд хажуугаар нь өнгөрсөн залуус гоочлон өдөж, шар айрагт халамцан улайсан, халцархай илгэн цамцтай эр, Байгалийн цаадах орос ардын дууг ээдэрсэн хэлээр хашхирч гуугчиж яваа нь үзэгддэг сэн. Ийнхүү элдвийг бодлогошрон явсаар НЕВА мөрний хөвөөнд ирснээ мэдэв.

Хотод үдэш болж байлаа. Гэгээ тасрахын хирд асаасан олон дэнлүү яралзаж манай тэндхийн «Зулын 25»-ыг санагдуулан байв. Жил бүрийн өвлийн сүүл сарын 25-нд Бурхан багш Зонхов богдын таалал төгссөний өдөр гэж шөнө гадаа зул барьдгийн гадна зуны эхэн сарын арван таванд Бурхны мэндэлсэн өдөр гэж бас нэг сүрхий юм болдог зэрэг багын мэдэх зүйл санаанд орно.

Нева мөрний элбэг уст мандал оройтох тусам харлан мэлтэлзэж голын боржин чулуун хашлагыг дагуулан аргамжсан модон онгоцууд үл мэдэг хөдлөн нөгөө эрэгт нь орос маягийн сүмүүдээс эрс ангид гадсан шовх оройтой Петропавловскийн сүм торойн харагдахуйяа хотоос баруун тийш өртөө орчим байдаг их петрийн орд шилтгээн санаанд орном. Тэнд би хэд хэдэн удаа очсон юм. Энэхүү чулуун хотыг цул намаг дундаас босгон байгуулсан тэр их хааны ордны орчим газар бол үнэхээр сонин гайхамшигийг сэтгэлд өгүүлнээ билээ. Ордны өмнө үелэн буусан олон шатаар нь усан хүрхрээ шаагин наадаад, алтан хайрст загасан баримлын амыг нэгэн их хөлөг баатар эр хүчлэн ангайлгаснаар ус оргилон цацраад, ойр тойрны олон усан оргилуур нь нар, бороо, шүхэр тэргүүтнийг дүрслэн наадаж солонгорон цацарна. Түүнээс жаахан цаашилж хоёр талыг нь modoор эмжсэн гудамжаар явтал гэнэт газар тэнгэр нийлэн цэлсхийж Балтын далай хэмээх их ус цэнхэртэнэ. Үүнийг ажихуйяа тэнгэрийг гишгэсэн мэт сэтгэгдэнэ. Баруун тийш ажвал Кронштат хэмээх усан онгоцны буудал арал харагдана. Би Балтын далайн эрэг газар тийн зогсоходоо тэрхүү зах хязгаар нь үл үзэгдэх далайн уудмыг гайхан биширч миний амьдрал ч

бас ийнхүү зах хязгаар нь үл үзэгдэх их замын дунд явна даа хэмээн бодож билээ!

Нева хэмээх орос газрын домогт мөрний гантиг хашлагыг налан зогсох zuураа энэ бүхнийг эргэцүүлж амжаад, эцгийн бие мую байгаа хийгээд эдүгээ буриад нутагтаа буцах болсныг санагалзахын зуур их далайн дундах сэлүүргүй завь мэт салхины урсгал аясаар дайвалзах миний энэ амьдрал юугаар төгсөх бол хэмээн бодож зогсоно. Энэ завсар би явч харь нутагт идээшиж үл чадахаа мэдэрсэн юм. Гэвч би шинэ эцэгтээ ихэд дассаны дээр нэлээд оросжуу байдалтай болсон минь дээрх бодолд хориг тавин хөндөлсөж:

— Чи лам багшаа хилэгнүүлсэн, тээж төрүүлсэн эх, тэвэрч өсгөсөн эцгээ орхисон, хөлд орохтой зэрэг хөрс шороог нь гишгэсэн ахин олдошгүй алтан нутгаа аяны замаар сольсон шүү дээ гэж хэн нэгэн хүн хэлэх шиг болоод учиргүй олон бодолд унагадаг байлаа. Удалгүй дорно зүг байгалийн чанад дахь нутагтаа буцахаар шийдсэн эцгийн бодол надад таалагдсан юм.

Би мөдхөн байгаль далайн барааг харна. Бас аян талын шалтаг олдвол монгол нутагтаа буцаж очих далим ч гарч юу магад хэмээн гэнэт бodoхдоо хэн нэгэн хүн биднээс өрсчих гэж байгаа мэт сэтгэгдээд яаравчлан Васильевын арлын ойролцоо орших худалдаачин эцгийнхээ гэрийн зүг алхлав. Оросын баатар цагаан хааных хэмээн манай монгол газар ихэд эрхэмлэн хэлэлцидэг энэ газар бас л зовлон жаргал, нүгэл буян хоёр зэрэгцэн байх бөгөөд энэ бүхнийг нүдээр үзсэн миний бие энэ ертөнц дээр чухамхүү дээр дорын ялгалгүй тэгш жаргалант энхжиний орон үгүй ажээ хэмээн сэтгэх авч хүрээ хийдэд сууж ахуй үест багш ламын айлдсан мөнөөхөн хойд насны диваажин гэгчид бас л сайн итгэж өгөхгүй агаад тэнд очих ч хүсэлгүй амьтан Петербургийн нэгэн гудамжаар алхаж явахад тэр цагийн хуанли гэгч он тоолын хуудас 1914 оныг зааж дэлхийн нэгдүгээр дайн гэгч эхэлжээ хэмээн уулзсан учирсан бүгд шивнэж байсан цаг билээ.

* * *

— Зээрэгц, дундаа алхаад марш! Баруун мөр түрүүлээд! Иванов чи зүүн тал руугаа сүхээр дэлсүүлчхээгүй биз дээ... Нэг хоёр, хэмээн шар үст ахлагч Васильев хоолойгоо сөөтөл хашхирна. Би цэрэгт ирсээр бараг жил шахаж байна. Эцэг Бадмаев маань Петербургээс буцаж Борзя өртөөнд хөдөөх эдлэндээ ирснээс хойш удалгүй таалал төгслөө. Тэр

оройг би яахин мартах билээ. Удтал хөхүүлэн ханиалгасан аав маань намайг нэг орой өөр дээрээ дуудаж билээ.

Би эцгийнхээ хонхойсон ухархай, хавчгар хамар тэргүүтнийг үзээд хирдхийн зогстол:

— Зээ Юндунов минь, хөвүүн минь. Чи aan гэж бай! Би чамайг тээж төрүүлж тэвэрч өсгөөгүй боловч эцэг гэж хэлэх эрхтэй гэж бодож байна. Би чамтай долоон жилийн өмнө уулзахад чи балчирхан хөвүүн, би тарган цатгалан амар амарлингуй хүн байсан бол одоо чи настай идэр эр, би орноос хадаастай хатангир өвчтөн болжээ. Зээ хөвүүн минь сонсогтун!

— Чи их сайн хүн болох хэрэгтэй гэж хэлээд элдвийг бодсон шинж харцанд нь тодорч нэг хэсэг чив чимээгүй байснаа ахин ам нээж,

— Надаас хойш чи өнчрөх л байх даа. За яах вэ. Хорвоо хүнийг хайрлах биш дээ. Чи эр зориг барьж хүн шиг яваарай. Чи их зүггүй, бас айлгамтгай хүн шүү. Айлгамтгай эр, зан чинь надаар дуусгавар боллоо гэж мэдээрэй! гэж хэлээд нэг хэсэг өвчиндөө шаналан дуугүй болсноо,

— Ер нь чи яваандаа нутгаа тэмцэх нь дээр болно шүү гэж билээ. Би тэр үгэнд нь гомдох ч шиг болоод хэлэх үг олдохгүй дэний л дэрийг нь засаж суулаа. Эцэг минь дэрэн доорх даалингаасаа нэг мөнгөн шагай гаргаж ирээд ихэд амьсгаадан үгээ ганц ганцаар нь зөөн өгүүлсэн нь:

— Энэ чамд эд хөрөнгө болохгүй ч энх тунх үеийг минь сайн сайхныг сануулж, мал буянтай монгол орныг чинь мартуулахгүй байхын бэлгэдэл болог! гэж билээ.

Түүнээс арвитай удалгүй эцэг Бадмаев минь насан эцэс болж байшингийн хаалгыг аяархан хаан гарахдаа би өөрийн эрхгүй нулимын мэлтэлзүүлж, намайгаа ингэж орхих гэж дээ хэмээн орь дуу тавьж хэдэн өдөр архидаж билээ. «Үхсэний хохь, амьдын зол» болдог нь энэ ертөнцийн жам юм болохоор дөчин есөн хоног нь бараг өнгөрөөгүй байхад эх Санжидмаа, мөнөөхөн эцэг бид хоёр Дарасуны рашаанаас буцаж явахдаа шоолон дуулж явсан, «Хамбан дээлийнхээ цаана ханцуйгүй цамттай» Ёлхнийн гэргий болоод цагаач хөвүүн би хайхрагдах хүнгүй харь нутагт хоцорч билээ!

Нэг сар хиртэй хийсэн ажилгүй, хэлүүлэх ч хүнгүй архидаж наргиж, орос буриадын сууринаар тэнэж, Агын дацангийн хурал номыг хүртэл үймүүлж явснаа нэг өглөө эцгийн дурсгаж үлдээсэн

мөнгөн шагайг үзээд сэтгэл уяран байтал тавхайн Дугар гэдэг танхай эр надтай уулзаж Атаман Семёноваар толгойлуулсан Дагуурын засгийн газар гэгч байгуулагдаж байгаа гэж яриад намайг цэргийн дарга болох хүн гэж магтан, архиар шахаж суулаа. Шөнө орой боллоо. Хөгшин буриадууд архинд халцгааж, «Заян наваа дуулалдан, Хаагаа хөөгөө» болцгоож байтал зэргэлдээ гэрт бүсгүй хүний аврал гүйн хаширах чимээ сонсогдоход би яaran гарав. Хаалганы түгжээг мулт түлхэн орвол зүүн талын орон дээр хоёр хүн, дээр дороо орон ноцолдож унтрах шахсан зулын гэрэлд бөхийсхийн үзвэл мөнөөхөн Тавхайн Дугар, Софья хэмээх нэгэн эелдэг зант сайхан бүсгүйтэй ноцолдож байх ажээ.

Софья бол миний найз Петягийн дурлалт хүүхэн бөгөөд царай зүс сайхантай, бие бялдар чийрэг, булчин шөрмөс чанга, махлаг цулдамхан бүсгүй билээ. Дээш огшоосон бanzал хэмээх олон хуниаст хувцасны цаанаас царс шиг чийрэг цагаан гуя үл мэдэг цайран цухалзах бөгөөд Дугар ухаан мэдрэл алдан түүний дээр тэгнээтэй байхад нь миний хилэн хөдөлж сарвасхийтэл татаж өргөөд ирлээ. Тавхаев ихэд уурсаж,

— Аа муу бэлтрэг, улааны зулбасга чи, тийм бий гээд ташаан дахь нagaанаа тэмтрэхэд нь би нүдэн дунд нь нэг өгчилгөж орхилоо. Тэр, дуу алдан нүүрээ дарахад нь бууг нь булааж хэд өшиглөөд Софьяг яaran дагуулж гараад орос дүнзэн байшингууд дундуур хэдэнтээ сүлжсэний эцэст ухнын хөг мэт их сахалт, баавгай хэмээх Медведев өвгөнийд оруулж өгөөд гарч билээ.

Би тэр хавьд орогнох газаргүй болж мөнөөхөн Тавхаев надаас хариугаа авахаар заналхийлэн байгааг дуулаад бүлэг дээрэмчний ахлагч мэт зоргоор аашлагч тэрхүү зэвсэгт этгээдээс буруулан Удэ хотын орчим ирж хэсэг байзнаад нэгэн өдөр санаа шулуудан цэрэгт орж билээ.

Асрамжилж авсан эцэг минь намайг Юндунов гэж дууддаг байсан учир би түүндээ чих дасаж нэршээд, ламаар угаалгаж олсон халх угсааны Лодой гэгч нэрээ Юндуновоор сольчихсон маань бүүр ч завшаан болж оросын харьят буриад гэж ойлгогдон цэрэгт их л амархан орж сайн дураар алба хааснаа бодоод зогсож байтал түрүүнээс хойш шинэ цэргүүдийг аашилж, хөл гарын сургууль хийлгэж байсан ширүүн зантай ахлагч Васильев санчгийнхаа үсийг гараар илбэн цэрэг малгай доогуураа оруулангaa Юндунов гэж дуудахад давхийн цочих

мэт болоод биеэ чангалан цэгцэлж ахлагчийн өмнө очоод хөлөөт хавиран тавхийтэл ёсолж зогслоо.

* * *

Хуучин тооллоор 1917 оны 10 дугаар сарын 25 буюу алдарт 11 дүгээр сарын 7-ны шөнө боллоо. Манай цэргийн ангийг сар гаруйн өмнө Петерград хотноо татан ирүүлсэн бөгөөд энэ үдэш бидний хэсэг цэрэг эрс, Петерпавловскийн цайзын зүг амьсгал дараан ширтэж суугаа нь энэ билээ.

Манай анги дотор хувьсгалт цэргийн штаб хэдийн байгуулагдсан бөгөөд большевик намын гишүүд үе үе ирж яриа хийн Оросын хувьсгалын учир утгыг сэнхрүүлдэг байсан юм. Эргэн тойрон зузаан хэмээр хүрээлэгдсэн Петрпавловскийн гозгор оройт сүм нүдний үзүүрт харагдсаар ахуйд түүний тухай эцгийн ярьсан зүйл санаанд орж байв. Их хаан Петр 1-ийнхээс эхлээд Александр хүртэлх оросын хаадын шарилыг цул гантиг авсанда хийж тэрхүү сүмийн дотор агуулан хадгалж байдаг юм хэмээн ярьсныг эргэцүүлэх бүр хөдөө багадаа сонссон зүйл санаанд ордог байж билээ.

Хүрээ хийдийн томоохон мяндагтныг мөнх бусыг үзүүлсэн хойно нь давсалж хатаагаад суварган дотор завилуулан суулгасан нь ер хэчинээн жил өнгөрөвч муудах янзгүй хэвээрээ байдаг гэлцэхийг олонтоо сонссон тул энэхүү сүм доторх тэр нөгчсөн хаадын биеийг мөн тийм янзтай тавьдаг юм болов уу хэмээн эргэцүүлдэг сэн! Сүмийн хашааны баруун талд төрийн гэмт хэрэгтнүүдийг чандлан хорьдог аймшигт тамын гяндан байдаг гэлцдэг бөгөөд тэнд мөнөөхөн миний, Чита хотноо гав гинж орон сав тэргүүтнийг нь үзсэн Чернышевскийн биеийг хорьж байсныг нь хожим дуулсан юм.

... За өнөө шөнө тэр аймшигт шорон хуучин төртэйгөө нурж ойchoод хар бор ажлын улс хаан ширээг эзлэх болдог байжээ хэмээн бодож байтал тийм! гэх шиг нөгөөх цайзын нэгэн гэгээвчээр гал улсхийж, тэхийн сацуу их бууны дуу нирхийгээд явчих нь тэр!

Хаалтаа зад тавьсан их мөрөн адил үй олны түрхэrsэн урсгал, хурууны завсар бүхнээр нэвтрэн ирэх ус шиг гудамж бүхнээр сад тавиад, туг улалзан, уриа лоозон түрхрэн нижигнээд буу тажигнан, нэг мэдэх нь өвлүүийн орд хэмээх их байшингийн эгц өөдөөс харсан гулдан хаалган доогуур орж явчихлаа.

1812 онд Напелеоныг ялсны дурсгалд зориулан босгосон Александрын багана хэмээх их өндрийн оройд хэрээс өргөсөн эмэгтэйн зогсоо дүрс энэ бүхнийг гайхах мэт ширтээд, өвлийн ордны өмнөх уужим талбай түмэн хүний хөл дор хотолzon доргих шиг санагдана.

Баруун тийш зэрвэсхэн хараад Исакиевын дуган хэмээх алдарт барилгын бөмбөгөр орой урьдын адил гялалзаад түүний араар хошууран бүрхсэн олны дунд Петрийн морь цоройж байгаа үзэгдэв.

Алдарт уран франц Монфреннийн зохиосон төслийн амилал болж хэтэрхий өндөрт сүндэрлэн боссон энэ сүмийн үүх түүхийг эцэг Бадмаев минь олонтоо шагшин ярьдаг байсан сан. 40 жилийн турш баригдсан уран гайхамшигт энэ барилгын зөвхөн өмнө талын царсан хаалга 20 тонн хүнд бөгөөд 55 янзын уран дүрс хээ сийлбэр ганцхан энэ хаалганд байдгийг үзэхэд ижилгүй их нарийн ажлын дүр зураг санаанд буудаг байж билээ!

Улангасан тэмүүлж ордны 2 дугаар давхарт гараад буудалцаж байхад ер бусын гоёмсог чимэглэл, таазны үнэт зургууд нь эмээх мэт эмзэг үзэгдээд, баганын хоёр талаас буу тас тасхийн хэн нэгний амьгүй бие унаж ирэхэд түүн дээгүүр харайн урагш дүүлж байлаа. Би анх харсан даруй нүдэндээ итгэсэнгүй. Гарынхаа алгаар нүүрээ шудран сайтар харвал манай ангийг удирдаж явсан Васильев гэгч өнөөх шар үст дарга маань харин биднийгээ эргээд буудаж байгаа харагдлаа.

«Урважээ» гэж бодол эгшин зуурын цахилгаан шиг харван орж ирээд бууны гохыг дарж орхитол, тэр муухай хашхиран гүйвалзаж намайг чиглүүлж буу шагайсан боловч амжилгүй гар нь сулран буугаа алдаад өөрөө савж ойчих нь харагдлаа. Түүний дээгүүр хүмүүсийн хөл гялалzan өнгөрсөөр олон тийшээ салаалсан хонгил өрөө тасалгаагаар буудалцан бужигнан арилж өглөө. Александрын заал хэмээх нэгэн их алтадмал өрөөний булангаар тойртол, дайзтай сум бэлхэнцэглэсэн хэсэг эрс түр засгийн газрынхныг баривчлан тутуяа хаягдлаа. Хажуугийн нэгэн өрөөнд үсрэн орж үл таних улаан цэргийн хамт хааны садан төрлийнхний хэдэн хүнийг барьж авлаа. Энэ шөнө ийнхүү янзтай өнгөрч үүрээр түр зуур үүрэглэж байтал нэг хүн мөрөн дээрээс угзчин сэрээж — нөхөр минь чамайг хувьсгалт цэргийн штабт нөхөр Петров дээр дуудаж байна гэлээ.

За энэ ч лав хэрэг бишидлээ шүү! Нөгөө золигийн гайт Васильевыг буудсан хэрэг босож ирэв бололтой. Урvasан хэдий боловч

дарга хүнийг тэгж шууд буудчихдаг нь арай түргэдэх шиг боллоо гэж дотроо нэлээд түгшүүрлэн бодол болж явтал,

— Хүүе Юндунов гээд нэг хүн намайг дуу алдан тэвэрлээ.

Толгойгоо өргөж үзвэл: Петя! Юутай их бөөн баяр вэ? бид хоёр дэмий л хэлэх үгээ олж ядан

— Үгүй чи гэлцэн нэг хэсэг болов. Гэвч би нэгэнт дуудагдаж яваа болохоор түүнийгээ нэлээд зовуурилан хэлбэл тэр:

— Эцгийгээ ал! Юу л болов гэж! хэмээн ажиггүй хэлснээ намайг цааш явахад бас л сэтгэл нь зовчих шиг болоод тамхиа асаан нааш цааш холхиж байгаа харагдав. — Чамайг иртэл чинь энд хүлээж байна шүү гэж хашхирахад нь би толгой дохиод хэдэн байшин өнгөрч уг дуудсан газраа ирлээ.

Гэтэл уг хэрэг санаснаас өөрөөр эргэж би түүн дээр баяр хөөртэй буцаж ирлээ. Миний бүх явдлыг яриулсны хойно:

— За буриад хөвүүн Юндунов чи Оросын ард түмний хийсэн Октябрыйн их хувьсгалд оролцож гавьяа байгууллаа. Чамайг өнөөдрөөс эхлэн улаан цэргийн дунд тушаалын дарга болголоо гэхэд нь би сэтгэл хөдөлж,

— Би бол монгол хүн байгаа юм. Миний нэр Лодой гэдэг. Монгол улс гэж та мэднэ биз дээ? гэж заяатай л хэлчхэлгүй амаа барив.

Тэндээс хөл хөөр болон Петя дээрээ эргэж ирээд хоёулаа хууч хөөрөн Нева мөрний сэруүн тунгалаг эргээр алхлаа.

— Петя би чиний дурсгасан бэлгийг одоо болтол хадгалж яваа шүү гээд мөнөөхөн Борзя сууринаас салахдаа өгсөн хутгыг үзүүлж,

— Би үүгээр чинь Удэ орчмоор тэнэж явахдаа нэг ёсондоо хоолоо олж идэж явсан шүү. Лам нар мах идэж чаддаг боловч мал алж чаддаггүй хойно доо. Идэш гаргаж улай хийхийг нүгэл хэмээвч идэх уухын цагт нүглээс айхаа больчиждог сүжигтэн олон байдаг нь надад зол болж би энэ хутгаараа буриад нарын хонийг монгол ёсоор өрцлөн төхөөрөөд ам хөдөлгөн амь зууж явлаа гэж ярихад Петя маань тосон авч,

— Чиний өгсөн сахиус гэдэг зураг номтой бурхныг би заяатай л алдчихаагүй шүү.

Түүний чинь их үнэтэйг би ингэж нэг мэддэг байна. Надтай нэг Польш аянчин тааралдсан юм. Би санамсаргүй сонирхуулчихсан чинь Үүнийгээ надад зарчих! Хэчинээн ч хамаагүй мөнгө өгье! Энэ Дорно

дахины маш өвөрмөц урлаг юм байна. Манай Польшийн Варшавт бас ийм олон гоё бурхан цутгуулсан.

Өнгөнийх нь гоё гэж яана! Яг л алтаа алт! Хийцийг нь чи ямар гэж санана! гэж магтсанаа ахиад л надаас энэ зурмал бурхнаа өгчих гэж шалж билээ. Тэр цагт би цэргийн амьдралд байж гэдэс дундуурхан явсан тул нэг сайн цадаж авахад гэмгүй л санагдсан л даа.

Гэлээ ч сайн нөхрийн дурсгал учир хэрхэвч үрэхгүй гэж шийдээд өгөөгүй юм гэхэд нь би инээж,

— Өө Петя минь манай тэнд тэр чинь тэргээр ачаад ируулсэн ч элбэг олдоно. Хожим би нутагтаа очоод чамд зөндөөг явууламз. Чи тэр Польшдоо их үнээр зараад баяжсан ч бараг болно гэсэнд бөөн инээд болж баахан хөхрөлдлөө.

— Чи монгол нутагтаа буцах санаа байна уу? гэж Петя дээрх ярианаас өлгөн асуухад нь би санамсаргүй санаа алдаж:

— Боломжтой цаг ирвэл нутгийнхаа барааг харахыг бодолгүй яах вэ дээ гэлээ. Тэгээд бид хоёр түрүү түрүүчийн дурсгалаа батжуулж Нева мөрний хөвөөнд тэврэлцэн зогсож байгаагаар зургаа авхуулж билээ.

Тэр цагаас хойш орчлонд олон ч явдал болж, олон ч он улирчээ.

* * *

Юндунов хэмээх өвгөн Лодой бид хоёрын яриа тэр шөнө ийнхүү Үүр цайтал шахам үргэлжилж билээ. Энэ бүхий түүхээ ярьж гүйцээд өвгөн маань өнөөх дүнсэн тамхиныхаа шавхрууг гүвж тамхia хэд сайн сорлоо.

— Аа тэр жилийн бидэнд үзүүлдэг зураг чинь ийм түүхтэй юм бий. Попов гуай та хоёр тэхэд нээрээ ч залуухан байж дээ гэхэд өвгөн толгойгоо дуугүйхэн дохиод бохь нь шарчигнасан гансныхаа толгойд бараг үнс нь үлдсэн тамхia сүүлчийн удаа сорлоо.

— Та тэгээд монгол нутагтаа хэдийд ирсэн юм бэ?

— Тусlamжийн улаан цэрэгтэй цуг арван нэгэн оны (1921 он) зуны эхээр нутагтаа ирсэн юм.

Замдаа цагаантантай нэлээд үзэлцэж явсаар хүрээг чөлөөлөхөд Сүхбаатар жанжны гол ангитай цуг хотын хойд талаас нь орж ирж байсан юм даа.

— Тэхлээр өөрөө Октябрьн хувьсгал, монголын хувьсгал хоёрт хоёуланд нь оролцож явсан хүн болж таарах нь ээ дээ.

— Одоо тийм шүү л ухаантай юм болж байна даа.

— Та ер нь өөрийгөө ийм их гавьяатай хүн гэдгээ мэддэггүй байжээ дээ.

— Хээ цэгийгээ ал! Ямар юмных нь гавьяа байгуулах вэ дээ.

Хорин гурван оны үед орос цэрэг хойшоо буцахад, би оргood нутагтаа үлдчихсэн юм чинь, нэг угээр хэлбэл би чинь хар багаасаа эхлээд л оргодол болсон хүн!

Сүүлд нь хэрэг түвэг болж илэрвэл яршиг гээд Юндунов гэж явснаа хүнд дурсах байтугай өөрөө ч бараг мартахын мөн болж явлаа.

Харин багадаа муу Петягийн хувийн ногооны газар бас жаал зугаа юм тарилцаж байсан юм гэсэндээ тария ногоонд овоо дүйтэй гэгдэж хараа Ерөөд хэдэн жил луухаануудтай хоршин ногоо тарьж амьдарсан юм даа.

— Өөрийнхөө жинхэнэ эцэг эхтэй уулзсан уу?

— Үгүй ээ, үгүй. Сураг дуулбал цөмөөрөө л өнгөрсөн юм шиг сонсогдсон!

— Миний л мэдэхийн энэ «Цагаан оломд» лав тав зургаан жил болоо шив дээ.

— Тийм ээ бараг арваад жил боллоо. Өлзийгөө өгсөн сайхан газар шүү. Ямар ч гэсэн л нутагтаа ясаа тавих хувь зохиол надад байсан л юм байна гэж хэлэхдээ Лодон өвгөний царайд гүн догдлол тодорч нэг юм санасан мэт хоолойд нь баяр хөөрийн аялгуу сонстоод,

— Хүүе Шарав аа, би нөгөө багын танил Чой бандитайгаа уулзсан шүү гэлээ. Би ихэд сонирхон дэрэн дээрээ тохойлдон суугаад

— Яасан сонин хэрэг вэ?

Хэзээ тэр вэ гэлээ.

— Генерал Попов та нарыг 1944 онд ирээд явснаас чинь хойш «баатар» хотод урьсан урилга ирлээ.

Эхний удаад дэмий л гайхаш төрж, юу ч болов энэ удаа азная гэж бодоод байznаж байтал ахиад дууддаг байна шүү. Тэхлээр нь энэ хойдох цагаан Цэндмаагаар нэг зузаан дээл хийлгэж аваад Улаанбаатар орлоо л доо.

Юуны өнөөх арван нэгэн оныхтой зүйрлэх юм биш. Эргэн тойрон байшин барилга, машин тэрэг жигтэйхэн! Сангийн байранд тогтмол хоолтой нэг их жаргалтай хүн сууж байтал нэг өдөр маршал Чойбалсан хүлээж авах болсныг дуулгалаа. За тэгсэн чинь олон сайд дарга нарын дундуур явсаар маршалтай золгож хуучилж байтал гэнэт,

- Та чинь ингэхэд нөгөө Содном гавжийнд байсан хөх банди жаал Лодой байж таарах нь шив дээ гэж хэлдэг байна. Би нэлээн гайхаж,
- За тийм! гэж хариу тавихад маршал инээмсэглэж,
- Танай хүрээн дээр хүрэн дээлт банди гэж нэг дүрсгүй жаал байж байгаад бас л өөр шиг чинь оргочихсоныг санаж байна уу гэхэд нь би,
- Саналаа, саналаа гэж духаа алгадаад ингэхэд тэр Чой банди чинь та өөрөө байна шүү. Бид хоёр чинь багын танил улс юм гэж баярлан дуу алдаж билээ.

Тэгээд улсын нийслэлээс бөөн баяртай буцаж ирээд хоёр ч он өнгөрлөө.

Тэгтэл саяхан Улаанбаатар хотод ахин дууддаг байна. Хүрээд очсон чинь ийм сайхан юм хүлээж байдаг байна гээд өвгөн орныхоо дээд талын шүүгээний нүднээс нэг нандигнан боосон юм гаргаж өгснийг үзвэл Партизаны 450 тоот үнэмлэх, байлдааны гавьяаны улаан тугийн одон хоёр байж билээ.

УУЛЫН САЛХИ¹

1 ДҮГЭЭР БҮЛЭГ

Үдшийн Москва түг түмэн зулаа асаажээ. Ирж байгаа хавар цаг гэдэг инээмсэглэж байгаа бүсгүй шиг цаанаа л нэг урьхан. Трамвай тарчигнан, машин дүнгэнэн хүн олны тасралтгүй хөл хөдөлгөөн ар араасаа үерлээд их хот завсар зайгүй нүргэлэн шуугин байвч тэр бүхэн эс анхаарагдан гагцхүү хаврын цэнхэр униар будангуйран, цэл ногоон моддын мөчир сэргээлзэн шуугихаас өөр юмгүй мэт сэтгэгдэнэ.

Тийн явсаар Зана Москва голын эрэг дээр ирэв. Голын ус толиотон гялтганаж долгис хаялан шал пал хийх завь шуугин хурдлах тэргүүтнийг ажиглан мөрний эргийн хашлага дээр гар тохойлдон зогсохуйд элдвийн бодол түүнийг гүйцэж ирэв.

Гэгээвч нь ярайсан мөнгөн цагаан өнгөт онгоц, хөнгөн зогсоолоос хүржигнэн хөдөлж мөрний харги уруудан явж эхэллээ. Дотор нь зуушны газар үйлчилж шампаан дарс цалгисан шилэн хундаганы хоёр талаас жаргалтай харц мөргөлдөн байгаа нь лавтай.

Занын хажууханд амрагууд шивнэлдэн, хаашаа л харвал ижил хосууд гараа атгалцан, мөрөө түшилцэн зогсоно.

Зуугийн тал насалсан эр эм ч сая нийлсэн хоёр лугаа адил сугадалцан гараа атгалцан явах ажээ.

Радио хоолойгоор ямар нэгэн хүн, мөрөөдөнгүй санаашралт сэтгэлээр дуулан байх нь яагаад ч юм бэ нэг л сэтгэл уярмаар санагдана.

Соёл амралтын төв цэцэрлэг өнөөдөр урьд урьдаасаа хөлтэй болсон мэт. Гэтэл энэ бүхний дунд Зана өөрөө ганцаардмал санагдах нь өөрт нь үл ойлгогдоно. Мижид гэдэг нэр сэтгэлд нь орж ирэхтэй зэрэг гэнэт түүнд хамаг бодлын уяа тайлагдах шиг боллоо.

Энэхэн мөчид түүний сэтгэл долоон мянган мод газрыг алслаад дорнын сайхан монголдоо хэдийн хүрчихсэн байлаа. Дээгүүр нь олон он улирсан хан бодын ар, дэлгэр ивээлт хатан Туулын хөвөөнд аж үйлдвэрийн комбинатын аварга яндан үзэгдэнэ.

Гутлын фабрикийн уудам хашааны хаалга нээлттэй мэт сэтгэгдэнэ. Тэнд Занын учралт хүүхэн Мижид нь ажилладаг билээ.

Тийнхүү Зана Москвагийн шуугиант үдшийг огоорч эргэн тойрныг эс анзааран, сэтгэлт хүнтэйгээ хэрхэн учирснаа сэмхэн дурсан санав.

... Халх голын түүхт тулалдаанаас өмнөхөн 1938 оны зун цаг, тэр оройг яахин мартах билээ. Дөрвөлжин хоншоортой гялалзсан хар хром гутал дээр цэрэг хөх дигнаалан өмд, ногоон даавуу цамц өмсөж алтан өнгөт аралтай шар суран бүснээс шар модон хуйтай маузер буу зүүсэн идэрхэн цэргийн дарга хязгаарын цэргийн зэвсэг авахаар хот орж ирээд шпороо тас тасхийлгэн золбоотой сэргэлэн алхаж явсан нь өөр хэн ч биш Зана байлаа. Тэр бээр нэгэн орой «Арвын клубт» кино үзсэнээ санана. Тэндээс, дугуй бор царайдаа хөөн хар нүд нь зохисон мэт золбоотой гялалзах агаад хондлой даван суналзах хоёр салаа гээзг нь чухамхүү морин тачанкийн жолооч сон бол шүүрээд авмаар санагдах 20-иод насны цэвэр гоолиг бүсгүйтэй танилцаж билээ.

— Та ийм гоё ганган, бас тэгээд цэргийн дарга хүн! Тэхэд би бол ерийн л хар бор ажил хийдэг, тоосонд даруулж, тосонд хутгуулж явдаг хүн шүү дээ! гэж бүсгүй нэг удаа хэлжээ.

Зана тэр бүхнийг эдүгээ эргэцүүлэхдээ алс хол суугаагаа мартаад чухамхүү Мижид дэргэд нь байгаа мэт,

— Хаанаас даа хэмээн амандаа шивнэв. Тэгснээ сэхээрэн үзвэл нөгөө л Москвагийн хөл хөгжөөнт үдэш үргэлжлэн үргэлжилсээр ажээ.

Хaa л бол залуу хосууд!, зарим нь цэцэрлэгийн гүнд байрлуулсан нууцхан суудалд халуунаар тэврэлцэн, нүд хариулан үнсэлцэж, зарим нь Москва голын эргийн хашлага налан усны урсгал ширтэн зогсоцгоно. Хүүхдийн шуугиан, хөгшдийн халуун маргаан яриа, бүсгүй хүний жаргалтайгаар цангинатал инээд алдах энэ бүхэн хүний орчлонгийн зол баярыг илтгэх буюу! Энэ сайхан энх амгаланг сооюх аюул бүү учраасай! гэж сэтгэлдээ эргэцүүлэхийн сацуу халх голын догшин тулааны өдрүүд яагаад ч юм бэ? санаанд нь орж ирэв.

Ай даа дайн! гэж шүд зуух санаа алдахын аль нь үл мэдэгдэх байдлаар өөртөө шивнээд тамхia асаав. Гашуувтар утааг нь шунаг сороход хязгаарын цэргийн амьдрал, таньдаг нөхдийн нь дүр төрх санаанд нь орж ирэв.

1934 оны намар цэрэгт татагдан нутгийнхаа залуустай дарвин сэтгэл хөөрч, жагсаалын түрүүнд жороо цагаан морин дээр улаан туг өргөөд давхиж явахдаа ёстой хийморь нь сэргэх шиг санагджээ.

Орсон буур шиг цагаан толгойлсон Отгон тэнгэр хайрхны барааг далд орохын хирд үзэж өнгөрөөсөн амьдралаа үгүйлэх мэт дурсан санав. Хантай — шир уулын аймаг, цэцэн сартул хошууны танхимд 13 настай орсон Зана хоёр жилийн хойно сурлагаар сайн гэгдээд хот орох гэж хөл хөөр болж явсан билээ. Тэр үедээ тэргүүн зэргийн өндөр гэгдэж байсан Уушаан дэнгийн урд орших эгнээ цагаан байшингийн нэгэнд Мэнгэт багшаар ном заалгасаар жил өнгөрч, Дэмид захиралтай ерөнхий сургуулийн хаалгыг татжээ. Тийнхүү тэр бээр монгол улсын анхны маршал, өрлөг жанжин Дэмид хэмээх тэр нэгэнтэй амьд ахуйд нь нүүр тулгаран учирч үг яриаг нь сонсож явсан ажээ. Гурван хаврын тооройн цэцэг дэлгэрэхийн хирд тэр бээр Зөвлөлтөд хуягт танкны сургууль төгсгөж ирсэн билээ. Хожим нь бие муудаж нутагтаа буцсан авч өнөөдөр ийнхүү эр цэргийн эгнээнд дахин орж эх орны алтан хилийн зүг явна даа гэсэн бодол төрж, нэгэн үе баясаж нэгэн үе ард хоцорсон аав ээж нутаг орноо санагалzan явав.

... Занын бодлыг голоор яваа усан онгоцны дуу тасалдууллаа. Цахлай цагаан өнгөт тэрхүү онгоц хажуухны зогсоолд ирэхэд салхи сөрөн сэлүүцэж голын мөнгөн долгисыг өгсөн уруудах хүсэлтүүд олноор шахцалдан авай.

Зана ч бас тэнд орж нэгэн тохилог суудал эзлэн аваад мэлтэлзсэн хүрэн дарс болор жүнзэнд хийлгэн авч шимэх зуур өмнөх бодлоо үргэлжлүүлэв.

... Халх голын тулалдаан!

Баянцагааны нуруунд олон танк эгнэж зогссоныг үүрийн бараанаар алсаас харахад нэн сүрлэг үзэгдэж билээ! Халх голын бургас мөн ч шигүү сэн! Гайтай хар бөмбөгөнд үндсээрээ тас хяргуулан огил татуулан унахдаа мөчир бүхнийгээ энхрийлэн тэвэрч байх шиг санагддаг сан. Нэг удаа тагнуулд гаражад мөнөөх л бургас тус болсон.

Тайван цагт бол ёстой хайрт хүнтэйгээ мөр түшилцэн халх голын усанд тольдож, ханын бургаас огтлон гэрээ шийрлээд амьдарч суумаар аятай хязгаарсан билээ.

Гэтэл одоо бол хаанаас буун дуу тас хийх бол? гэхээс биеэ барьж сэрэмжилнэ. Эргэн тойрны байгаль орчин ч бас гэнэтийн цочир чимээнээс болгоомжлон дуу чимээгээ хураах мэт дүнсгэр баргар үзэгдэнэ.

Дурангийн шилэнд голын нөгөө эрэг... Түүнээс цаашлаад хайлааст манхнууд хөхрөн харагдана.

Гол нэлээд булингартай, хaa нэг хөөст долгион эргээ цохилно! Дээгүүр нь шавартай хутгалдсан өвс ногоо, бас эзнээ алдсан цэрэг малгай, цус улайрсан марль эсэн бусын юм хөвж явна.

Дайн гэдэг байгальд хүртэл амар заяа үзүүлэхгүй юм даа. Гэвч энэ бүхэн дээр онц анхаарсангүй. Харин ганц цагаан дэрсийг л нүд алдахгүй ажигласаар байлаа. Тэр дээрс нэг л амьтай юм шиг санагдаад байлаа. Нэг ил гарч нэг далд орно. Тэхдээ хажуугаараа биш босоогоороо цухалзах нь нэг л жигтэй! Тэгснээ голын урсгал сөрөн хөвж эхэллээ.

За энэ ч нэг жиг ургалаа шүү. Далдлалтаа сайн хийж аваад дагуулан харсаар байтал зэлүүд эрэгт хүрэхийн сацуу дээрс маань хүн болж хувирлаа. Хараач муу самуурайг Аргагүй л усч золиг юм даа. Ганц муу цагаан дээрний голоор амьсгалж явдаг байна.

— Гараа өргө! гэхийн сацуу ганцхан полхийгээд усандаа үсрээд орчих байх гэхээс болгоомжлон түүнийг бургасанд орохыг хүлээсээр байлаа.

Амьдаар барих хүсэлдээ автсаар бургасан дотроос шилүүс шиг үсрэн барилцаад автал өрөөсөн гараараа яг л сэлэм шиг шуун дээр цавчаад авдаг байна шүү. Заяатай хуга цохичихсонгүй.

Самуурайн сургуульд үзсэнээ өөрөөр нь бараг туршчих шахсан тэр золигийг өвдөглөөд хүлж байхдаа ч уур нь хүрсээр л байлаа.

Энэчлэн тагнуулд явсаар нэг удаа самуурайн офицерыг гэнэдүүлэн буудаж, сүмийг нь олзолж байлдааны зураг төлөвлөгөөтэй нь хүргүүлэхэд хороон дарга эх оронч Дугаржав их баярлаж байж билээ.

Эр хүнд ийнхүү золбоотой сайхан нэг өдөр байхад золгүй явдал тохиолдох өдөр ч бас байх юм даа. Халх голын тулалдаан дууссанаас хойш домогт баатар Дандарын хороонд алба хааж билээ.

Тэгтэл уршигт өвчин тусч хэвтрийн хүн боллоо. Тэр цагт бөндгөр толгойд минь бөмбөрцөг дэлхий олонтоо орж гаран үймрэл зовнил өдөртөө хэдэн удаа ноолж байдаг сан.

... Спасскийн цаг уянгалан дуугарах бүдэг чимээгээр тэр, бодлоосоо хагацаж, усан хөлгийн цонхоор Кремлийн зүг ширтэн харав.

Хөлөг Кремлийн ойр орших Москва голын гүүрэн доогуур шургаад улмаар баруулан яваа аж!

Буянт Василийн сүмийн алаг орой чалма малгай ороосон дундад азийн өвгөн лугаа адил санагдах агаад цаахна нь Кремлийн хана,

Спасскийн цагны алтан хүрээн дотор зүү нь аажуухан эргэж үзэгдэнэ.
Улсын их дэлгүүрийн олон шовгорууд үелэн, өмнүүр нь хүн амьтан
олноор хөлхөнө.

Лениний бунхант индрийн гантиг холоос хүрэнтэн харагдана. Зана
их багш Лениний шарилыг үзсэнээ санана. Түүнд Ильич түр зуур
зүүрмэглэн байгаа мэт санагджээ.

Хүн төрөлхтний зол жаргалын дуулал болсон Кремлийн оройд
улаан одон таван хошуу гэрэлтэн туяарна.

Энэ одны гэрэл гэгээ эх болсон монгол нутгийг минь гийгүүлсэн
юм! хэмээн Зана бодно.

Ойрх зогсоолд буусан Зана Москвагийн нам тайван үдшийн
сайханд автан явсаар Александрын цэцэрлэгийн араар тойрон гарч
Метрополь буудлын ойролцоо харгдах хувьсгалын метроны хаалгыг
татаж ороход халуун салхи өөдөөс үлээв. Газрын гүнд орох цахилгаан
шат зогсолтгүй, урssaар түүний нэгэн гишгүүр нь Заныг авч явсаар
хүрэл баримлууд багана бүхэнд нь хүдэр чийргээр эгнэн ярайсан газар
доорх харшийн зогсоолд хүргэж өгөв. Удалгүй цахилгаан тэрэг шуугин
ирж түүнийг аваад тэрхүү олон мянган хүний шуугиант цувааг буух
буух газар нь саатах юмгүй хүргэж өгөхөөр хонгил дундуур агсан морь
шиг арилж өгөв.

* * *

Зана гэнэтийн их дуу чимээнээс болж нойрноос сэрлээ. Нээлттэй
салхивчаар гудамжны шуугиан нэвт орж ирнэ. Алсад галт тэрэг
тасралтгүй гууглан, машин дүнгэнэн дуу чимээ ихсэж, хүмүүс энд
тэндгүй бөөгнөрөн ярилцах нь Москвагийн ерийн амьдралтай нэг л
нийцэмгүй санагдана.

Тэр бээр хөл нүцгэнээр яaran алхаж явсаар тасалгааны буланд
байгаа радиогоо залгавал: Гитлерийн фашистууд итгэлийг эвдэж 3ХҮ-
д цэргийн их хүчээр довтолсон тухай ярьж байлаа!

Дайн эхэлжээ!

Зана яаравчлан хувцаслаж гадагш гарлаа. Саяхан болтол амар
тайван байсан хот тосгон, сандал тавиулаад амраг хосыг хүлээсэн
цэцэрлэг, салаа мөчирт нь анхны цэцэг цухуйсан модод, саарал утас
хар утас дайны утаагаар бүрхэгдсэнийг санахаас гол нь харлаж явлаа.

Халиуран цэцэглэж байгаа хаварт дайсагнасан мэт эрх чөлөөт
amar дагшин орны хил хязгаараар түрэн ирсэн фашистын хар хүчний

эсрэг шударга хүн бүхэн өндийн босох цаг болсныг тэр ухаарч явлаа.

Түүний хажуугаар нэгэн хижээл эмэгтэй нулимсаа арчсаар өнгөрөв. Бодвол үр хүүхэд нь дайны анхны галын шугам дээр албан хааж байсан ч юм бил үү. Хүмүүсийн нүд улам ч том болчихсон юм шиг, галт тэрэг, үйлдвэрийн яндан хоёр дуу дуугаа авалцан гууглаад хүн, машин урьдынхаасаа хэт олширсон юм шиг санагдана.

Москва хотноо суух монгол улсын элчин яамны газар очиж элчин сайд Жамсрангийн Самбуу гуайд бараалхан хэрхэх учраа асуусанд,

— Нэгэнт л эмчлүүлэхээр ирсэн хойно биеэ бүрмөсөн илаарьштал байзнана биз! гэдэг хариу өглөө. Зана тэндээс Арбатын баян гудамжийг өгсөн буцах зуураа мөн л нөгөөх дайны тухай бодлогошрон явав. Түүний сэтгэлд Адольф хэмээх Гитлерийн хурц хамар, буруу тийш самнасан үс, дээд уруулдаа тавьсан өндөг дарам сахал, харгис мөртөө бусдыг өөртөө татаж сүрдүүлэх хүчин нуугдсан мэт харц тэргүүтэн санагдаар заримдаа тэр нь туг дээрх хохимойтой солигдон орж ирсээр байлаа. Нууц байгууллага дахь тоогоор нэрлэгдсэн гишүүдийн 7 дахь нь байсан худалдаачны хүү тэр бээр хөрөнгө мөнгөөр дорийтон ядарсан Германы тэр цагийн ерөнхийлөгчтэй 2 сая франкаар тохиролцон нууцын эрхлэгч болоод улмаар төрийн дээд эрхэнд гарсан намтрыг нь санахын чацуу Ари үндэстний угсаа хэмээн дэврээж герман үндэстнийг дайнд хөөргөн оруулсан арга мэх хийгээд хүнд байдаг муу чанар бүхнийг хөхүүлэн өсгөж дэвжээсэн хорт санааны нь тухай номоос үзсэнээ эргэцүүлийнэ.

Галт тэрэгний буудал дээр очвол ачаа тээвэрлэж байх нь тааралдан чадлын хирээр тус хүргэхийг хичээсэндээ хайрцаг савтай юмнаас зөөлцөж явав.

Тийнхүү хийх ажилтай болж дундад Ази руу ч сайн дураараа юм зөөлцжээ. Москвагаас Уралд зөөх ачаа бараа, айл амьтныг нүүлгэлцэж хэдэн долоо хоног болсны хойно нэгэн өдөр улаан талбайгаар өнгөрч явтал алс явах бололтой аяны үүргэвч бүхий олон зуун хүний дунд нүдэнд танил монгол царай харагджээ.

— Сайн байцгаана уу?

— Сайн, та амархан сайн уу?

— Сайн, За ингэхэд та хоёр чинь хаанахын улс байна даа.

— Би монгол, энэ залуу маань халимаг хүн! нэр нь Доржиев,

— За баярлалаа сайхан танилцлаа. Миний нэр Зана гэдэг.

— Миний нэр Халтархүү Завхан аймгийн Цэцийн урд талаар нутагладаг.

Хүүе тэгвэл та бид чинь нэг нутаг, тэр дундаа нэг аймгийн улс байна шүү дээ.

Би Завханы Сантмаргацын хүн!

Ийнхүү тэд хaa холын Москвад халуун дотно танилцав.

Тайван цагт бол лав Ази маягийн зоогийн газар орж, эсвэл амралт цэцэрлэгээр хамт зугаалах сан биз! Дайны түгшүүрт үед юун тийм юм санахтай мантай, Халтархүү маахуур гаргаж тамхилав.

— За ингэхэд та нар хaa гэгчийг зорьж явна даа.

— Аа бид үү? Бид нар өөрсдийн сайн дураар тулалдахаар явж байна. Фашистад эзлэгдсэн Белоруссын нутагт очиж партизанчилна.

Сургуулийнхаа амралтаар нутагтаа буцалгүй орос ах дүү нартаяа хир чадлаараа тус хүргэх гэсэн юм. Аа харин та хүсвэл бидэнтэй хамт явж болно шүү.

Зана энэ гэнэтийн үгэнд самгардан багын зангаар шилээ маажин бодлогошров.

Ард маань гурван муу бүсгүй дүү байдаг. Бас Мижид маань дуулаад бүүр сэтгэлийн өвчин болдог болов уу?

Заныг ийнхүү бодолд автан зогстол хажуугаар нь цэргийн цуваа зориг золбоотой тажигнан гишгэж хувьсгалын дуу аялсаар өнгөрөв.

... Хээ цэс миний байж байгаа царайг харав уу? Тулга тойрсон дэмий юм бодоод л... Энэ орос цэргүүд манай газар дээр бидний төлөө хэчинээн цусаа урсгаж явсныг мартах гэж үү. 1921 он. За бас 1939 он. Тэхэд би хүртэл эдэнтэй хамт байлдаж л явсан. Хөөрхий минь мөн ч олон хүн эргэж ирээгүй халх голд цусаа урсгаж ясаа тавьсан шүү дээ.

Тэр чинь бас л эхтэй эцэгтэй, эхнэртэй хүүхэдтэй улс байсан шүү дээ. Ямар...

— За та яах гэж шийдэв дээ,

— Би юу? Би явна аа. Та нартай цуг явна. Харин бийгээс би л байна шүү дээ. Өөр юу ч үгүй, буу зэвсэг хоол хүнс алин ч байдаггүй.

— Тэр талаар зоволтгүй ээ. Бидэнд хүрэлцээтэй бий. Монгол хүн мохдоггүй шүү дээ. Тийм ээ Зана аа гээд Халтархүү мөрийг нь алгадаахад Доржиев тал өгөн инээмсэглэж байлаа.

... Галт тэрэг дохиогоо хангинуулан баруун тийш давхисаар хоёр хоног явсны эцэст нэгэн багавтар хотын ойролцоо үүргэвч бүхий хагас мянган хүн вагоноос буулаа.

— За энэ таны буу зэвсэг, бусад хэрэглэл чинь! гэж хэлээд Халтархүү Занад нэлээд хүнд ачаа гардуулсныг үүрч аваад уул өгсөхөд ууцыг нь дарж амьсгал нь нэлээд давхацалаа. Битүү модонд орсны хойно партизан отрядын дарга хүмүүсээ арав арваар нь хэсэглэн хувааж тус бүрд нь үүрэг зорилгыг ярьж өглөө. Халтархүү, Зана, Доржиев нарын 10 хүн нэг бригад болж Доржиев даргаар, Халтархүү туслахаар нь томилогдлоо.

Бас тэдний хэсэгт радио станц үүрсэн цэнхэр нүдтэй сэргэлэн байрын бүсгүй хуваарилагдан ирж нэрээ Нина гэж танилцууллаа.

* * *

Тийнхүү замд гарсаар хэдэн өдөр болоход Зана нөхдийнхөө занг төдий л сайн мэдэж чадсангүй. Тэр ч байтугай би чинь ингэхэд ямар шүү янзын улстай дайралдаж орхив доо! гэж эргэлзэх үе ч тохиолдох болов. Энэ нь ч бас учиртай л хэрэг!

Халтархүү, Доржиев, Нина гурав сав л хийвэл германаар ярилцдаг байлаа. Тэр ч байтугай нэг үдэш Доржиев Халтархүү хоёр герман цэргийн даргын хувцас өмсөөд явчихад нь хаачих гэж байгааг Нинагаас асуусанд:

— Дуугүй байвал дээр юм биш үү? Таны үүрэг бол яв! гэсэн газарт явж, хий! гэснийг гүйцэтгэх ёстой гэдгийг бодож байвал сайн гэж нэлээд хүйтэвтэр анхааруулжээ. Түрүүн ч гэсэн Нинагаас юм асуухад тэр толгой дохих буюу сэгрэх төдийхнөөр хариулж, заримдаа уцаар нь аргагүй ам нээхдээ:

— Дуугай яваач! Бид дайсны хүрээн дунд явж байгаа шүү дээ! гэж зэмлэдэг байжээ.

... Би дээ ер нь ингэхэд юутайгаа л нийлж орхив доо байз. Эд арай Германд биеэ худалдсан амьтад биш байгаа даа. Саяын хоёр лав германчууд рүү явлаа шүү гэж бодсон Зана дуугаа хураачхаад бууныхаа замгийг арчин суухдаа,

— Би ч бас эднийг бодвол цэргийн хүн шүү! Хэрвээ эднүүс тагнуул байгаад намайг Германчууд дээр аваачих гэх юм бол чинь нэгийгээ үзэлцэж, нэхийгээ хуваалцана даа гэж өөрөө өөртөө ярьжээ. Үдэш явсан хоёр үүрээр эргэж ирэхдээ хэдэн машин дайсны цуваа устгаснаа яriv. Тойрон суусан нөхөд нь их л урам зориг орж,

— За тэгээд хэмээн яриулсаар байв. Гагцхүү Зана дуугарсангүй.

— За даа юу л бол? явсан мөрөө буруулж хүний толгой эргүүлэн худал ярьж ч байгаа юм билүү хэмээн бодож суув. Тэдний авчирсан нэгэн шуудайг задалсанд нэгэн орос хүн янгинатлаа хүлүүлчихсэн гарч ирэв. Тэр хүнийг, Доржиев нар тусгайлан байцаасны эцэст модны ёроолд буудаж унагаад шороогоор буллаа. Үүнийг хараад Занын сэтгэлд урьдын эргэлзээ улам ч бат суудал эзэлж дэмий л халаасан дахь эвхмэл тонгоргоо дуу гардаг юм бол ёо гэтэл нь тас атган зогсож байлаа. Тэд өдөр нь хад бартаанд нуугдаж, шөнө нь явдаг байлаа. Ийн явдалд Занын төдий л сайжраагүй биеийн ядрал ихсэж нойр ихэд хүрэн явуут үүрэглэх ажээ. Байсхийгээд онгоцны улин исгэрэх зэвүүн дуу агаарт хадаж цаг ямагт ямар нэгэн техникийн дуу хүнгэнэн үе үе сум шунгинан түгшүүрт дайны хөлд газар дэлхий уйлагнах шиг шавартай зам хөл доор хойно хоцрон хаягдаар байлаа. Ойн гүнд хоноглохоор буудаллахад Нина антен босгочдоод станцаа ажиллуулж эхлэв. Үүнийг залхуувтар янзаар харж зогссон Зана удалгүй уйдаж модны ёроолд унтахаар яаран явав.

... Эр бор харцага нь жигүүртээ хүчтэй
Идэрхэн залуу насандaa даанчиг ажимгүй явлаа
аяа хөөрхий алдрай мину зээ

гэж найрын эхэнд суугаа өндөр хөх өвгөн хаанаасаа гарав аа? гэмээр сүрхий тамиртай хоолойгоор нургилуулан дуулж гаражад гэр дүүрэн олноор түрлэг өргөн дуулцгаана. Хул дүүрэн айраг хүртэл дугараа өргөн тэлэх дууны эгшигт автсан мэт бидэрлэнэ.

Зана ихэд цангаснаа гэнэт мэдэрч хул хулаар айргийг дор нь суллахад сөнгийн хажууд байгаа нутгийнх нь залуу эр дүүргэн өгсөөр байна.

Гэтэл нэг харах нь ээ тэр зүс таних залуу эр бус Мижид байлаа.

— Тийм ээ Мижид! яах аргагүй өөдөөс нь инээмсэглэж байна.

Олон хүн дотор хэн хэн нь дуугарч үл чадна.

Зана гадагш гарах дохио өгсөнд Мижид ойлгов, бололтой үүдээр агаар цэлсхийв.

Зана хойноос нь гарлаа. Гадаа их сэргүүн салхитай хүйтэвтэр байх шиг, Зана халуун гэрээс гарсандаа тэр үү хий хавчин дагжиж чичрэх янзтай болов.

Мижид ойр харагдахгүй дэмий л ийш тийш харуулдан зогстол мөрөн дээр хүн гараа тавих шиг болоод эргэтэл Нина байлаа. Энэ чинь

яагаад энд ирдэг билээ гэж гайхширан «Нина» гэтэл Зана чи даарч байна уу? гэх шиг болов.

... Нүдээ нээтэл эргэн тойрон цав цагаан цас... хөрзгөр тэнгэр хөнхийн ширтэж, жихүүн одод хүйтэн гэрлээрээ хайрах шиг гялалзаад жиндүү жавар сэнгэнэж байх ажээ. Зана өндийхдөө хажуухандаа Нина сууж байхыг харлаа. Тэр нэлээд даарсан бололтой мөрөө эвхээд бөгцийн суух нь өрөвдөлтэй санагдав.

Гэтэл Нинагийн гадуураа өмсдөг арьсан дотортой оготор цамц хөл дээр нь хучаастай байхыг үзээд уярангуй зөвлөн дуугаар,

— Нина гэж дуудлаа.

— Анхны цас уналаа. Өвөл болжээ хэмээн Нина өгүүлээд уйтгарт цэнхэр нүдээрээ тэнгэрийн хаяа ширтэнэ.

Түүний хэлснийг давтах мэт эргэн тойрны мод битүү цасанд даруулсан мөчрөөрөө үе үехэн дохилзоно. Хар хэрээ тэнгэрт гуаглан туриах гүйлдээд уйтгарт хүйтэн өвөл ийнхүү хүрээд ирдэг байжээ.

Ногоон гацуур дээр цагаан цас цайраад Нинад лав шинэ жилийг дурсуулсан биз ээ!

Тэр эмэгтэй гүн бодолд автан дайн дажингүй амар жимэр агсан цагийнхаа явдлыг бодно. Алтан хавар шиг охин хонгор насыхаа онгон тэнүүн үдшийг тэр бээр яахин мартах билээ. Сэтгэлд нь Коля гэх нэгэн нэр ургахын сацуу сам бараг хэрэглэдэггүй сэгсгэрдүү шар үстэй, дүрсгүй байрын нэгэн залуу хүүгийн дүр байн шиг болно.

Тосгоны баян хуурч тэр бээр савхин гутлын түрийнд шургуулж өмссөн жадгардуу хөх костюм дээр задгай энгэртэй цагаан цамц өмсөж гимназийнхан шиг аралтай суран бүс бүслээд хэлтгий тавьсан саравчтай малгай дороос шар үсээ цухуйлгаж цэнхэр нүдээрээ анивчиж инээсээр Нинагийн болзоонд олонтоо ирдэг сэн билээ.

Ээ алым минь, алым минь.

Чи чинь хаашаа

Өнхрөх нь вэ.

Миний аманд орох юм бол буцаад гарч чадахгүй!

хэмээн баян хуурдаж арван зургаат тажигнатал бүжиглэх дуртай сан билээ. Бас заримдаа Новодевич дахь булаш бунхны газар очиж оросын алдар цуутны хөшөө дурсгалыг шагшин ярилцаж залуу хүү Алексей Пешковын гүн мөрөөдөлтэй зогсоо дүрсийг урнаар товоилгосон цагаан гантиг пайлуур бүхий Горькийн булаш бунхны өмнө удтал

зогсох буюу ойролцоо орших Гоголын хэрээст гантиг авсны дэргэд очиж харах дуртай билээ. Тэгсэн атлаа зохиолч болно гэж ярьдаггүй танкчин болно гэж өгүүлдэг ажээ.

Нина түүнийг өнгөрөгч намар цэрэгт явуулснаа санав.

Галт тэрэгний буудал дээр очоод үнсэлцэх хүсэл хэн хэнд нь их байсан ч аав ээжээсээ эмээгээд төдий л сайн тэврэлцэж чадсангүй дэмий л гар далласаар салж буцахдаа сэмхэн уйлж явжээ. Коля монголын хилд ойролцоо алс дорнодын цэргийн ангид очсоноо захидалд тодорхой бичиж ирүүлсэн билээ.

Энэ бүхнийг эргэцүүлэн суух зуураа хажуудаа байгаа монгол хүү Заныг хамт өрөвдөн суужээ. Үүнийг бас л над шиг нэг бүсгүй хүлээж байдаг байхдаа. Эх нутгаасаа хол газар, тэгээд бидний төлөө байлдаж явах, мөн ч нинжин сайхан сэтгэл шүү! Ер нь Дмитров, Иванов эдэнд хэлье байз. Муу Заныгаа арай өөрсдөөсөө илүү анхаарч халамжилж байлгүй горьгүй. Бие нь сайн тэнхрээгүй бололтой юм. Лав нутаг орноо их санадгаас зайлахгүй гэж бодоод сэтгэлийг нь засах санаатай.

— Занаа дайн мөд дуусна тийм ээ! гэж асуув. Энэ үгийн цаанаа дайн дуусахаар чи харина гэсэн утга байгааг тэр үед юм бодож байсан Зана төдийлөн сайн ухаж бодолгүй.

— Тийм ээ Мижид минь гэснээ андуурснаа мэдэж түгдрэв.

— Мижид гэж хүний нэр үү?

— Тийм ээ,

— Хэний нэр вэ?

— Миний...гэснээ Зана ичингүйрэх шиг дараачийн үгээ залгихад Нина, чи тэгээд Зана биш Мижид юм гэж үү? гэж асуусан нүдээр ширтэнэ.

— Миний таньдаг бүсгүй гэж Зана хэлэв.

— Лав сайн хүүхэн, тийм ээ гээд Нина эрхийгээ гозойлгон нүдээ ирмэхэд Зана хариуд нь толгой дохив.

— Доржиев. Халтар хоёр тагнуулд явсан алга л байна гээд Нина зовуурьтай байдлаар ой дундах зөргийг ширтэнэ.

— Эртүүдийн тэдний буудчихдаг орос хүн чинь ямар учиртай хүн бэ?

— Тэр үү? Чи урвагч Матвеевийг асууж байна уу?

— За тийм. Нэрийг нь ч би мэдэхгүй л дээ.

— Тэр чинь хүний шаар байгаа юм.

Өдий төдий сайн улсыг Германд ховлож бариулсныхаа шанг авч байгаа нь тэр! Зана бүхнийг ойлгосон бололтой толгой дохиод гэмшингүй инээмсэглэн Нинад дөхөж суув.

Ийнхүү тэр хоёр өдий төдий юм ярилцахын үүд нээгдэж өөрсдийнхөө түүхийг хүртэл бие биедээ ярьж сайн найз бололцлоо.

2 ДУГААР БҮЛЭГ

Партизаны бүлгийнхэн шөнө дөл явж нэгэн их хотын захад хүрлээ! Бүлгийн ахлагч Доржиев гараараа дохио өгч зогсоогоод нам дуугаар өөрсдийн гүйцэтгэх ажлын тухай ярьж эхлэв.

— Бид, хоёр хоногийн өмнө дайсны бүхэл ротыг унтаагаар нь сөнөөсөн. Тэхэд нөхөр Зана ихээхэн эр зориг гаргасныг бид бахархан тэмдэглэж байна.

Цаашид бид хүн бүрээс ийнхүү хүч зоригийг шаардана! гэж хэлээд нүдний булангаар цагаа хялам хийж харах зуураа дууныхаа өнгийг өөрчилж яаруухнаар хэлсэн нь:

— За нөхөд минь түргэлцгээ!

Одоо бидний өмнө 2000-аад хүнтэй дайсны цэргийн анги байна. Иймд хүчний илүүгээс зүрх алдаж шантрах хүн бий бол эртхэн хэлсэн дээр гэлээ. Тэгээд хүмүүсээ нэг тойруулж хараад өөрийнх нь бодож байсантай нийлсэнд ихэд баясах мэт.

— Үгүй шив дээ. За тэгвэл надтай Халтархүү, Иванов, Попов, Зана, Дмитров нар түрүүлэн явах болно. Хэрвээ бид илрэн баригдахад хүрвэл зоригтой тэсэлгээ хийж дайсантай хамт өнгөрөх болно.

Тэгвэл та нар эндээс яаравчлан зайлах хэрэгтэй гэж үлдэгсдэд хэлснээ явах хүмүүст хандаж,

— Зүсээ буруулан Герман цэргийн дарга болцгоох хэрэгтэй гээд өөрөө үлгэрлэх мэт яаравчлан хувцсаа сольж эхлэв.

— Манай Занад хиймэл хамар залгаж хар нүдийг нь будахгүй бол герман офицертой нэг л дүйхгүй нь ээ гэж алиа ярианд дуртай Дмитров энэ удаад тоглоом тохуугүй тогтуухан хэлээд Доржиевыг харахад цаадах нь нэгэнт шийдвэрлэсэн хойно гүйцээ гэсэн маягтай дуу шуугүй хувцаслаж дуусаад Нинагийн жижиг толинд герман цэргийн даргын рольд хир зохиж байгаагаа шалгах мэт байн барж байлаа.

Тэд мөлхлөө. Өвлийн жавар ташуурдсан шөнийн харанхуйд хад байц мэт нүд таглан сүндэрлэгч өндөр барилгын ёроолд тулан очиход нөмөр газрын дулаан дэргэдээс тосож түр амсхиймээр санагдав.

Гэвч юун тэгж суухтай мантай! Барилгын хананаас хүч заан хөшиж чангаасаар тоосго сугалцгааж эхэллээ.

Түгшүүртэй цочир цогт хүний хүч хэд дахин ихсэж ухаан хэд дахин нарийсдагийг Зана гэнэт мэдрэх шиг болоод, хэдий тэгэвч түүнийгээ бодох ч завгүй тоосго сугалан урт модонд бэхэлсэн тэсрэх бодисыг тэрхүү сул гарсан тоосгоны нүхээр шургуулсаар байлаа.

Эндээс түргэн зайлцгаа! гэсэн ахлагчийн дохиогоор ууланд үлдсэн нөхдийнхөө зүг яран хөдлөв.

Тэднийг ирэхэд үүр тэмдгэрэн алсын бараа бүдэг бадаг танигдахгүй болжээ.

Зана ихэд ядарснаа гэнэт мэдэж, Дмитровын асааж өгсөн тамхийг амандаа зууж хэд хүчтэй сорлоо.

Гүйцэд татаж ч амжсангүй тамхияа зуугаастай хэвээр үүрэглэчхэв. Гэнэт хүчтэй дэлбэрэлт болж агаар хэлбэлзэн, модны мөчирт тогтсон цас шилгээгдэн унахад тэр цочин сэргж ухас хийлээ.

— Та тогтох айлд! хэмээн наргианч Дмитрий инээмсэглэнэ. Доржиев, Халтархүү хоёр догдолсон байдалтай баруун урагш ширтэнэ. Тэр зүгт тэнгэр тулсан утас тоос босож гал дүрэлзэж харагдана.

Холбоочин Нина дуу алдан,

— Бид дайсны 2000 цэргийг үнсэн товрог болголоо гээд гүйн ирж нөгөө хэдийг үнсэнэ!

Байраа түргэн өөрчлөх болсон партизанууд гүн ойн дундуур туулай шиг үсрэн дүүлэн алга болцгоов. Зөвхөн тэдний гутлын ул гялалzan, мөчир тас няс хийх, цас цочмог хяхнах тэргүүтэн нь сүүдэр зураг мэт үзэгдээд өнгөрөхийг ажин харсан ойн бор хэрэм үзсэнээ дуурайх мэт модноос модонд хэдэнтээ дүүлэв.

* * *

Үүрч явсан хүнсээ аль хэдийн дууссан тэдгээр партизанууд өвөл цагийн тэр нэгэн шөнө дэмий л бие биедээ шахцалдан сууж цасны ус буцалган цайлж суухдаа хүн бүхэн дор дороо нэг л бодлогоширсон шинжтэй харагдана. Хоосон аяганд мэлтэлzsэн хар цай гол харлуулах авч «Оргүйгээс охинтой» гэгчээр дулаан галтай бүлээн цайтай байгаа нь бас ч яамай хэмээн санана.

- Халтар аа
- Аан юу гээв
- Өдийд чинь манай нутагт яг л цагаан сар болж байгаа даа.
- Ай даа яриа юу байх вэ?
- Оchoод ирж болдог сон бол мөн сайхнаа!
- Хэлээд яах вэ

— Тэгвэл би чамд хонго шаант, Нина-д хэвийн боов Доржиевт хүндэтгэлийн ууц, за тэгээд нөхдөдөө бүгдэд нь юм авчирна даа. Тэгээд энэ халуун хардаа овойсон цагаан тос, сүүл хөвүүлээд сууж байвал мөн догио! гээд үнэхээр тэгж байгаа мэт аягатай цайгаа том томоор оочиход нь Заныг өрөвдсөн Халтархүү,

... Энд дайн дажин болж байгаа болохоор манай тэнд ч ялгаагүй хэцүү л байдаг байх даа. Гэвч эцэг өвгийн уламжлалтай юм болохоор элбэг ховор боловч цагаан сар ч болж байгаа л даа гэж бодсон боловч түүнээ хэлсэнгүй, харин сэтгэлд нь ээжийнх нь царай тодрон, дөрвөн ханатай гэрийнх нь дотоод тавилга, бурхан тахил, боов шоов, тэгснээ эхийнх нь орны хөлд байдаг бор авдар үзэгдэх шиг болов.

Хир даг болсон ч тэр нь үл ажиглагдан гагцхүү дотор нь байдаг нарийн нандин юмныхаа өнгөөр туяарч байх шиг санагддаг тэрхүү, тос даарь, сааль сүү дусалсан бор авдраас ээж нь түүнд домbon сахар олонтоо авч өгдөг байсныг дурсан санав.

Хормойгоо дэвсээд дээр нь, зангиdsан гарын чинээ том ётон тавьж цай нүддэг сүхний мохoo ирмэгээр хэд тогшин буталж өгөхөд нь тэр бээр хоол олсон шувуухай адил хөөрөн баясаж бор шилбээ гялалзуулан оддог сон! Хөөрхий ээж минь гэж бodoхдоо Халтар хангинатал санаа алдav.

Зана ч үг дуугүй бодлогошрох ажээ. Ерөөсөө ч тэр дуу цөөтэй бөгөөд аливааг сэтгэлдээ бодлогошрон элдэв сонин явдлыг зохион хийсвэрлэж түүндээ итгэж явахдаа дуртай санжээ!

Багадаа хонь хариулж явахдаа аль хөглөдөг байсныг тэр гэхэв. Морины хурдаар давхиж, ташуураа сэлэм мэт эргүүлэн тархан бэлчсэн хоньд дундуур дайран орж ураа хашхиран бөөгнөрүүлэхдээ бүлэг дайсныг ялсан мэт төсөөлөх буюу эсвэл тэдгээр хонь ямаануудыг үзэгчид болгон тооцоод өөрийгөө улсын аль цуутай дуучин хуурчнаар зарлан Түдэв болон хуурдаж, Дорждагва болон дуулдаг ажээ!

Заримдаа ийм тийм хүн болно! тэгнэ ингэнэ гэж үлгэр зохион ганцаараа чанга дуугаар ярихад нь ямаанууд сониучирхан чагнах мэт

чихээ сэргийлгэн, уул толгод уяран сонсох мэт санагдах ажээ. Хар багынх нь явдал хaa холын орос нутагт түүнийг ийнхүү гүйцэж ирээд элдвийг дурсуулан ахуйд сэтгэл нь улам ч уярч нутаг, ус, танил садан, хайрт гэргий Мижидийгээ бүүр ч ихээр дурсан санав.

Уул усны уртыг туулж хад бартаа цас шалбаагийг туулахад нь сайн унаа мэт «Дайчин» гутлаа үзэх бүр ханийнхаа халамжийг тэр ямагт санадаг билээ.

Нина түүний цагаан ултай гутлыг партизаны нөхөр болсон ёстой дайчин гутал гэж нэрлэсэн юм. Нээрээ ч дайсанд гэтэхэд чимээгүй, хад бартаанд халтирч ханзардаггүй, Ханийн хайр оёдол бүхэнд нь шингэсэн онцгой түүхтэй гутал билээ.

... Мижидтэй «Аравын клубт» танилцсанаасаа хойш Зана удалгүй хязгаарын цэрэгтээ арга буюу буцжээ. Тэр үед хилийн ойролцоо байсан цэргийн дарга нар гэр бүлээ төдий л аваачдаггүй байсны гадна Мижид ч ажлаасаа гарах дургүйтэр байснаас шалтгаалан хотод нь үлдээжээ. Тийнхүү алс зүүн хил Улаанбаатар хоёрын хооронд Занаас Мижидэд «Мижидээс Занад» хүргэсэн захидал долоо хоног бүрийн шууданд үзэгдэх болж билээ.

Нэг удаа Зана захияа биш гутал хүлээн авчээ. Цагаан ултай гялалзсан хар хромон гутлын шажигнасан түрийнд,

— Энэ бол захиалж хийлгэсэн гутал шүү. Ханзарна гэж байхгүй гэж Мижидийн бичсэнийг хилчин эрс үзээд,

— Чамд дэндуү хайртай учраас цаасан дээр бичилгүй гуталдаа шивэн бичиж шүү дээ гэлцэн тоглоом тохуу хийлцэж байсныг санах бүрдээ Занын сэтгэл хөдөлдөг байв.

Энэ удаа ч гэсэн Зана мөнөөхөн гутлаа харж Мижид минь ч гэсэн бас л надтай хамт Зөвлөлт орныг өмгөөлөн фашисттай тулж явна! гэж бодлоо.

Нөхдийнхөө бодлогошронгуй чимээгүй байдалд түрүүнээс эхлэн санаа зовж байсан Нина,

— Занаа чи юм идэх сэн гэж бодож байна уу гэж гэнэт асуув. Хариу сонсоогүй Нина бүр шамдуугаар тэгсэн хэр нь эмээсэн байдлаар,

— Чи уурлаад байна уу?

— Үгүй ээ!

Нина инээмсэглэн,

— Чи чинь хэлтэй байсан юм уу?

Зана түүний зан төрхийг дуурайн давтаж хөмсгөө зангидан, уурсангуй байдлаар,

— Дуугүй яваач, бид дайсны хүрээнд дунд явж байгаа шүү дээ гэхэд цаадах нь тэсэлгүй инээд алдаж,

— Уухай, чи намайг дөнгөж байх шив дээ!

Энэ чинь их эд юмаа гээд бөөн цас шилэн хүзүүнд нь хийчхэв.

Үүнээс болж тэд сэргэн шуугилдаж зарим нь хүүхэд шиг цасаар шидэлцэн, Халтархүү, Зана хоёр өөрсдийгөө цоллон дуудаж барилдаж ч үзэв.

Оройхон хирд Сергей, Доржиев, Зана гурвуул партизан отрядаа хүнсээр хангах үүрэг хүлээгээд газар доорх нүхэн гэрээсээ гадагш гарахад Нина хичээнгүйлэн оёсон дулаан бээлийгээ Занын гарг хийж өглөө.

Тэд уулын бэлд бууж ирлээ. Дайтагч цэрэгтээ хүнс залгуулахаар яваа авто цувааны хоноглосон газрыг тагнан мэдсэн партизан эрс, болгоомжтой зугуухнаар мөлхөцгөөнө.

Дайсны манаа хайчлан зөрж нэгэн хэмээр алхахад хөл дор нь цас хяхнана.

Хоёр манааны холдохыг анаж байсан Зана сэмээрхэн ойртож нэгийнх нь ар дагз руу бууны бөгсөөр хүчлэн цохиход тэр яг — хийтэл ойчоод өгөв.

Сергей тэр мөчид үсрэн ирж манаачийн малгай бууг аваад нөгөө манаатай тулгаран очмогцоо хутга гялсхийлгэн унагалаа.

Шуудай шуудай талх үүрээд буцаж ирсэн тэднийг нөхөд нь хөл хөөр болон тослоо. Тэд шөнө дөлийн цагаар газар доорх тэртээ айван тайван сууж амар амгалан цагийг дурсан хөгжилдөв.

Тэр дундаас Нина бүүр ч их сэтгэл нь хөдөлсөн бололтой Алексей Петровичийн өгсөн бүтэн талхыг хоёр гардан аваад нүдэнд нь нулимс гүйлгэнэж байлаа.

Хайрт Колятайгаа тэр бээр гэрлэх ёслол хийснээ санана. Тэхэд ийм бүтэн том талхны захаас хоёул авч зулгаан идээд инээмсэглэж байснаа бодохтой зэрэг Колягийн нүд түүнд харагдах шиг болов.

Орос нутгийн гоолигхон хус мэт цасан цагаан өмсгөл дороос хайрт хүнээ ширтэхэд хуримын хувцастай эр нь түүнд ямар нэгэн жүжиг кинонд үзсэн мэт санагдаж байжээ. Ширээ дүүрэн зочин сууцгаан нэгэн зэрэг ярс хийсэн хундага өргөж Горький (гашуун) хэмээн хашхиралдана.

Тэр тоолон шинэ нийлсэн залуу хосын халуун уруул хоорондоо учралдан, хуrimын ширээг бүхэлд нь согтоох мэт санагдана.

Семён Петровичийн сэrvэгэр буурал сахал архинд дэвтэн норж, бас түүн дээр зууш сэрээдэхэд нь наалдаж үлдсэн байцаатай салатны илтэс үзэгдэнэ. Эмгэн Пелагия Ниловна өвгөнөө нударч амыг нь арчуулна.

Халамцсан зочид удалгүй бүжиглэж орос дүнзэн байшингийн шал доргион, авгайчуул эртний орос амьдралыг сэтгэлд санагдуулам урьхан задгай хоолойгоор хошин шог дуу дуулалдана.

Өвгөн Семён Петрович эмгэнтэйгээ сугадалцаад арван наймт шиг бүжиглэнэ. Тосгоны баян хуурч нэг мөрнөөс нөгөө мөрөө хүртэл хуураа дэлгэн орилуулж, хэн нэг нь түүний аманд хундагатай архи цутгана.

Коля дэргэд инээмсэглэн ирж гарыг нь барьж бүжиглэнэ! Хөвөн цас будрах шиг сэтгэл нэг л зөөлрөн уйлмаар ч юм шиг хачин санагдана!

Ийнхүү үргэлжилсэн Нинагийн бодлыг гэнэт тажигнасан буун дуу тасалдууллаа. Харуулын дохиогоор тэд цөм үсрэн босоцгоож хана түшүүлсэн буугаа аваад гараад,

Нина нүдээ арчингуут шүдээ зууж, автоматаа шүүрэн авав. Эргэн тойрноос буун дуу тажигнана. Бодвол дайсан бүсэлсэн бололтой.

3 ДУГААР БҮЛЭГ

— За нөхдөө бид өнөө шөнөдөө амжиж тэр харагдаж байгаа цэнхэр ууланд гарна. Наахна нь Белоруссын нийслэл Минск хот бий. Тэнд дайсан шоргоолж шиг бүжигнаж байгаа мэдээ аваад байна.

Та бидний зорилго бол галт тэрэгний шинэ цувааг хотод хүргэлгүй устгаж, saatuuлах, зэр зэвсгийн томоохон хадгаламжуудыг булаан эзлэх, дэлбэлж устгахад нэлээд хэмжээгээр чиглэгдэнэ гэж партизаны ахлагч хэллээ.

Тэдний өөдөөс цасан шуурга мөсөн хэлээрээ долоож, үүлс дээгүүр нь бүрхэн, өмнийг чиглэн нүүдэллэнэ. Партизанууд энэ бүхнийг сөрөн урагшилсаар байна.

Хавирга нэвт салхи, нимгэн хувцастай тэднийг дагжтал үлээж олон хоног нойр хоол муутай яваа хүмүүсийг сүрхий тамирдуулна.

Занын төдий л илаарьшаагүй бие нь хэдий тэсвэр гаргавч үл захирагдан өвчилж, үе үе нүд нь харанхуйлж газар дайвалзах шиг болно. Тэгэвч тэр өөрийгөө албадан явсаар билээ.

Нөхөд нь хааяа дэмжин сугадна. Ялангуяа Нина биесийг нь байн байн асууж сувилна.

Уулын салхи мэт үе үе довтлон шуургалж, уульхай дайсныг устган уул нурууг давж, ус намгийг гатлан, дайсны амар заяаг үзүүлэлгүй сөнөөгч, цаст уулын цагаан арслан мэт партизаны энэ бүлгийнхэн хоорондоо ах дүү мэт ижилдсэн сэтгэлийнхээ хүчээр тэсвэр гарган зүтгэж, урагш нь ахиулахгүй гэсэн мэт заналхийлэн балбах цасан шуургыг сөрөн ууланд гарч ирлээ. Зарим газар тэд төөрчихгүйн тулд бие биеэ бүсээрээ холбож явжээ.

Доржиев...

— За нөхдөө энүүхэн гүвгэрийн цаанаа дайсны нэг анги байгаа. Одоо түүнийг орчлонгоос тонилгох ширүүн тулаанд орно.

Нэг ууланд хоёр өөр ертөнц амьдарч байж зохихгүй гэж хэлээд заримыг нь тагнуулд явуулж, нэг хэсгийг нь байлдаанд бэлтгэж эхлэв. Нина, Зана хоёр нэгэн хадны ёроолд сууж бусдыгаа хүлээх зуур Зана Үүрэглэн, ядаргаандаа давхийн зүүдэлж сэргээр байлаа.

— Гранат чинь бэлэн үү?

— Бэлээн бэлэн

— Гал нь хaa байна

— Өвөрт бий.

— Чи шалгаж үз л дээ.

Зана цочмогхон өндийгөөд,

— Манайхан сураггүй л байна уу?

Нина,

— Чш чимээгүй дайсан ойрхон бий шүү! гэнэ.

Зана нөхдийгөө өрөвдөн суухдаа — энэ янзаар бол би эдэндээ дараа болох дог шүү! Яалтай юм билээ хэмээн гайхширан байтал Доржиев хүрч ирлээ.

* * *

Доржиевын ангийн партизанууд их хүчтэйгээ нийлэхээр цуцалтгүй урагшилсаар Минск хотод ойртон очиж явна.

Германчууд явж өнгөрсний мөр тодхон үлдсэн ойн зурvasaар тэд баруулан алхана.

Цасан дундаас их бууны гол төмөр цухуйн, чонын хоншоор мэт агаарт өлийлдөх агаад тэдгээрийн аль нэгний суманд бүслэхээрээ тас буудулсан цэргийн, тэр гэхийн тэмдэггүй болон сэглэгдсэн бие дайралдана. Танкны гинжинд няц даруулсан хүнийг хараадаа Зана золтой л шүднийхээ завсраар хаширчихсангүй, бие жихүүцэх шиг болно. Дайн гэгч ийм байdag ажээ.

Монгол хүн ийм юман дундуур өдөр шөнөөр явах нь битгий хэл, оршуулгын газраар ч тэр бүрий ойртдоггүй сэн билээ. Дайны хөлд дайрагдсан эдгээр хүмүүсийн амьд ахуй үеийг Зана сэргээн бodoх бүр сэтгэл нь аягүй болж байв.

... Амьдын жаргалыг эд, хир эдэлсэн улс юм бол доо? Өнөөх олон Бургуудын нэгнийх нь томоохон ресторанд мушгиа шаргал үстэй галуун хүзүүт бүсгүйтэй дарс шимэн эрхлэн наадаж байсан болов уу? Эсвэл тэхийн бэнчингүй ч эр байсан юм бил үү? Силезийн нэхмэлчний хүү ч юм билүү. Силезид очоогүй боловч сэтгэлд нь тэдний тухай төсөөлөл амилж, гунил шингэсэн нүдтэй, хурц эрүү, шовх хамартай эмэгтэйчүүд тортог болсон дэнлүүний гэрэлд шөнө орой болтол ажиллан, бөхийж чилсэн биеэ хaa нэг тэнийлгэн, талхны хөрөнгөөр хийсэн хямд ундаан залгилсны дараа хамар дээгүүр нь хөлс нь бурзайн гарч ирж байгаа нь харагдах шиг болном. Тос даасан саравчтай малгайгаа духодуулсхийн дарж өмссөн илгэн цамцтай ажилчин эр, уурын зуухны галд болчих шахсан боргил гараараа зүсэм хар талх авч ногоотой шөлөнд дүрж идэнгээ Лиза хэмээх эхнэрээ хайлалтайяа ширтэж Шленхаузен,

— Хүүгийнхээ толгойг илбэж байх шиг үзэгдэнэ. Гэтэл энэ... энэ... амьгүй бие тэр Шлен хүүгийнх нь цогцос ч юм билүү гэхтэй зэрэг Занын сэтгэлд ямар нэгэн түмэн гамшигийн хөг ая сонстох шиг болоод хараалт гурван өнгөт тугийг захлан, хуучин Герман чиний хүүрийг ороох баринтгийг бид нэхэж байна.

Бид нэхэж байна! хэмээн дуулалдах нь сонстох шиг болов.

Ойн агаарт хэншүү хярvas үнэртэнэ. Хоёрхон хоногт хоёр өртөө илүү явган явсандаа тэд ихэд ядарч нозоорсон нь илт боловч тэр дундаас хамгийн зүдэрсэн нь Зана өөрөө шиг санагдана.

Үүндээ тэр ихэд зовнивч өөрийгөө зөвтгөх хариуг сэтгэлдээ олж аваад үе бодолхийлнэ.

... Аргагүй ч юм уу даа. Бид ямар нэг их явган явж сурсан биш дээ. Өсөх наснаас өтлөх насыг хүртэл морины нуруун дээр явсан нь өвгөд

дээдсээс уламжлалтай юм чинь.

Саахалтын хиртэй газар ч явгалахаас залхуурч морио унана.

Харин өглөө морь барихад л аргагүйн эрхэнд явган явна даа.

Эндхийнхээр бол хоёр гуравхан км газар байгаа мориндоо очих гэж өглөөний шүүдэр буусан өвс ногоон дундуур нойтон зам татуулж хүрэх нь их л төвөгтэй мэт.

Гэтэл одоо өдөртөө өртөө гаруй гүйж байх юм. Хүн гэдэг дээ бас аминдаа тулаад ирэхээр айхавтар амьтан юм шүү. Занын энэ бодол хэчинээн сонин янзтайгаар хэдий хүртэл үргэлжлэх байсныг бүү мэд!

— Хүүе та минь! хараач тэр юу вэ? гэсэн Нинагийн дуугаар цочих шиг болоод ийш тийш сэргээлзэн харвал нөхөд нь ч ялгаагүй түүний заасан модны чигт ширтэцгээнэ. Нина бусдын амыг харуулдаад хариу олохгүйгээ мэдсэн мэт урагш хэд алхан харснаа,

— Хүүхэд байна! гэж хэлчхээд түрүүлэн гүйлээ!

Үр хүүхдээ үлдээсэн заримынх нь нүд халтираад харж чадсангүй. Хоёрхон настай охины булбарай бие модонд тэлүүлэн хадагджээ. Тарганы нухуур шиг танхил булбарай мөч бүхнийг нь чивчиртэл хүлж ар нуруун дээр нь аяганы чинээ хар будаг түрхээд бай болгон бууджээ. Хорхой ч болов биедээ хүрэхээр хөдөлдөгчлөн тэр балчир амьтан хирээрээ цахлан тийчлэхийг оролдсон нь илт бөгөөд мөнөөхөн хүүхдийн часхийтэл уйлан бархирах дуун сонстох шиг болж бүгдийн зүрхийг шимшигжүүлнэ. Биед нь бүтэн үлдсэн газар алга! Олон бууны сум шүүрэн шанага болтол сийчин нүхэлж, тэр бүхнээс нь цус садран асгасаар бүхий бие нь улаан нялга болоод тас хөлджээ.

Монгол хүн малаа ч ингэж тарчилгадаггүй шүү дээ. Тэхэд ингэх ч гэж дээ! гэхээс гол нь харласан Зана ахин ширтэхэд нөгөөх жаалын амьгүй бие арвалзан хөдлөх шиг нүд нь бүрэлзлээ.

— Фашист гэж хэн нэг нь шүд зуун битүү дуугараад,

— Яргачин! гэж Зана монголоороо хэлээд үс нь өрвөсхийх шиг болж хилэн бадран буугаа тэмтэрнэ.

Нина тэр хүүхдийн эх адил уйлан хайлан байж Халтар, Иванов хоёртой хамсран хүлгийг нь тайлна. Бүгд тэрхүү бяцхан биеийг хүндэтгэлтэйгээр өргөн явж Дмитрийн ухсан нүхэнд хийгээд дээрээс нь шороогоор булахад бүдгэрэн бүдгэрсээр хөөрхий түүний бие үзэгдэхээ болив.

Гэвч хүмүүсийн сэтгэлд тэр л хэвээрээ харагдсаар байх бололтой. Палаажаараа ороож оршуулсан Нинагийн хоёр хацрыг дагаж нулимсан

булаг урсаж аманд нь гашуу оргиулан ороход гашуун зовлонг амтлуулсан дайны уршгийг зүрхнээсээ дахин дахин мэдрэх шиг болсон тэр бээр, чулуу тойруулан орж шигтгэсээр өндөрлөөд эцэст нь цэх зогсон эмгэнэлтэйеэ ширтээд нөхдөө харна!

Доржиевын дохиогоор партизаны бүлэг замдаа орлоо. Хүн бүрийн царайд харамсал занал тодорч алхаа нь эрсхэн болоод, нүд нь гялалзана. Занын ядаргаа нь аль хэдийн алга болсон мэт бөгөөд үсрэхэд бэлэн барс адил догшин сүрлэг болоод ойн зөргийн замыг хүртэл өстэй мэт хилэнтэйгээр, «дайчин гутлаараа» чанга чанга гишгэчин явж билээ.

Хэрвээ энэ үед тэдэнтэй дайсны цуваа дайралдсан бол ёстой авах юмгүй болтол зад ниргэх нь илт бөгөөд тэрхүү германчуудаас амьд гарах хүн үгүй байсан биз ээ!

Хусан шугуйг өнгөрөхөд тэдний бараа тасран нөгөөх уйтгарт ойн чөлөөний өнчин булаш торойн торойсоор үүрд үлдлээ!

* * *

Зана, тэр нэгэн шөнийн аймшигт зургийг сэтгэлдээ эргэцүүлнэ. Тэр багаасаа байгалийн сүртэй үзэгдлүүдийг олонтоо үзсэн бөгөөд аянгын догшин гялбаа нүд яран зурс хийх, тэнгэр нижигнэн дуугарч, хад чулуу тажигнан цуурайтан хөх гал жирс хийх, ургаа мод салам ниргүүлэн хүхэр ханхлах тэргүүтэн нь багын оюунд аймшигийн мөрийг үлдээсэн боловч саяхны хэдэн удаагийн тулаанд үзсэнтэй зэрэгцүүлэхэд юу ч биш санагдана.

... Минск — Смолевич хотыг холбосон төмөр замыг өндрөөс харахад аргамж мэт мушгиран зурайна. Хол биш орших нүхэн хонгилын цаахнаас үл мэдэг цэнхэр утаа үе үе цухалзах шиг болно. Энэ бол галт тэрэг айсүйн тэмдэг! Хэрвээ төмөр зам дээр чихээ тавиад үзвэл зүрхэн түгшээ мэт нэгэн хэмийн цохилго эхлээд чичиргэнэх мэт байснаа эцэст чангаран чангаран түг түг нь сонстох буй заа!

Энэ замаар дайсны зэвсэг ачсан галт тэрэгний цуваа явдгийг тагнаж мэдсэн партизанууд отолтод суужээ.

Цаашаа хараад тасралтгүй дурандаж байгаа чийрэг цулдамхан биетэй Доржиевын бухан хүзүүг харах бүр Занад бяр хүч амтагдах шиг болно.

Эдний халимаг угсааныхан чинь ер нь зоримог улсын нэгэнд ордог байх шүү! Манж нарыг халимагаас гаралтай гэж нэгэн номоос

үзсэн санагдана.

Халимагийн нутагт найр наадам нь манайхантай адил байдаг болов уу? Хэрвээ бөх барилддаг бол мань Дорж...лав шөвгийн дөрөвт үлдэх дэг шүү гэх зэргээр эргэцүүлэхийн зэрэгцээгээр хулсан шугуйн барс мэт довтлон гэнэтийн цохилтоор зүрхийг нь үхүүлсэн партизаны удирдагчийг германы командлал 1000 рублийн хүн! хэмээн нэрлэж зар тараасныг нь бодохоос инээмсэглэнэ!

... Дааж ядтал юм үүрсэн тэдгээр хүмүүс төмөр замын зэвсэгт манааг хонь хурганаас амархан төхөөрч орхиод үүргэвчээ задлан тэслэх бодис гаргалаа. Замын залгааг тааруулан мина булж байхад яарсан зүрх түг түг цохилон, хөлс нүүрээр бөмбөрнө. Учир нь галт тэрэг хариугүй ойрхон ирж яваа юм санжээ. Замын төмөрт санамсаргүй шүргэхэд тэр яг л тэвдсэн хүний гар мэт чичиргэнэх ажээ.

— Түргэлээрэй цаг биднийг хүлээхгүй шүү! гэж хэн нэг нь амьсгаадан хэлэхэд,

— Ийм үед аль өрссөн нь л хождог юм даа гэж Доржиевын тайвуухан мөртөө шаардангуй хэлэх нь сонстоно.

Одоо бүр галт тэрэгний чимээ ойртон, их аадар шаагих мэт шуугин, басхүү эмээх мэт гууглан айсүй! тэд саахалт хиртэй гүйлээ.

Харанхуй шөнийн харлан дүнсийгч ойн бяцхан төгөл, хойноос нь сэтгэл зовниж суусан эх адил тэднийг тосон авахад, хэдхэн мөчийн дараа тосож байгаа аюулын зүг мөнөөхөн галт тэрэг албинд хөөгдсөн мэтээр довтлон ойртоно.

Дайн гэдэг ийм ажгуу!

Аль нэг нь үхлийн зүг өөрөө ч үл мэдэн тэмүүлж явдаг байжээ!

... Гэнэт чих дөжрөм хүчтэй тэсрэлт боллоо.

Харанхуйг зүсэн дүрэлзсэн улаан галын гэрэлд тэрхүү аймшигт үзэгдэл тодхон харагдана.

Ямар нэгэн аварга биет амьтан хясаанаас халих адил замын далангийн хажуу руу түр няр хийн унасан галт тэрэгний толгой, гал утаан дунд тэлчилж байгаа мэт үзэгдээд араас нь түрсэн олон вагоны дугуй, мангасын толгой мэт яралzan түүн дээр орших дөрвөлжин байшингууд бие биеэ түрж гүүр адил гүвийн нумлаж ирснээ хажуу тийшээ холбирон унах нь тун ч сүртэй байж билээ.

Түүн дотор явсан хүмүүсийн тухай бол төсөөлөх ч хэрэг юу байх вэ. Цөм няц үсрэн цусанд бялдсан нь илт бөгөөд ямар нэгэн аварга амьтан шархандаа галзууран тийчлэх адил шөнө орой болтол тэрхүү

гулдайсан хар үхдэл бүхий газраас аймшиг мөхлийн чимээ гарсаар байсан билээ.

Зана эдүгээ энэ бүхнийг эргэцүүлэн суухад түүний бодлыг бие биедээ дамжуулан шивнэлцэх мэт модны мөчир сэrvэлзэн шуугина.

Доржиев тэднийг байц бэрх өндөр уулын хад хясаанд дагуулан иржээ! Энэхүү өндрөөс хараад бэлд байгаа бүхэн алган дээр тавьсан мэт ил үзэгдэх ажээ. Баруун хойд зүгт орших дайсны зэвсгийн газрыг нөхдөдөө зааж өгсөн Доржиев, Халтархүү, Алексей, Петрович хоёртой хэдэн зүйлийг зөвлөсний эцэст тамхia нэг сайн ороож аваад шуналтай гэгч нь хэд сорсноо,

— За нөхөд минь бид амь сорьсон хамгийн том ажлыг өнөөдөр хийх болно гэж хэллээ!

Тэгээд түр дуугүй болж хүн бүхний хувь заяаг дэнслэх мэт эргүүлж тойруулж харснаа,

— Энэ их том зэвсгийн газар байгаа юм даа! Бидний авсан мэдээгээр бол энд олон зоригт эрс амиа үрсэн юм.

Өнөө шөнө үүнийг дэлбэлэх үүргийг дээд газраас авснаа та нарт дамжуульяа! гээд тамхia шаржигнатал сорлоо! Хэзээд шийдэмгий байдгаараа хэвшил болсон Доржиевын энэ байдлыг ажсан Нина, энэ бол зүрх нь шантарсан хэрэг биш, гагцхүү нөхдөө өрөвдөж, тэдний амь насны төлөө зовниж байна гэдгийг ухаарч,

— За найзууд минь тухтай амарч, хооллоцгоож, шинэ хүч авцгаая!

Бид маргааш үүрээр ингээд нэг тогоондоо хоол идэж жаргал зовлонгоо ярилцаж сууна.

Эсвэл...гээд үгээ тасалснаа гэнэт шийдэмгий байдлаар, эсвэл энэ их зэвсэгтэй цуг тэсэрч дайсны гарыг мухарлана. Хамгийн гол нь бидэнд ялалт хэрэгтэй! Тэгвэл бид маргаашийн нарыг ард түмэнтэйгээ хамт үзнэ гэсэн үг! гэж хэлээд тэд үлдсэн архиа хувааж уугаад бие биэ налан сууж дуулцгаав.

*Широко страна моя родная
Много в ней лес, полей и рек
Я другой такой стран не знаю
Где так вольно дышит человек*

гэсэн уяруун сайхан дууны эгшиг тэдний зүрх сэтгэлийг догдлуулан, эмэгтэй хүн хaa явсан газраа орчлонгийн гоо сайхныг санагдуулж

ергөнцийг баясгадагчлан Нинагийн цээл хоолой чулуунд хөглөсөн хөгжим шиг цангинах байлаа.

Халтархүү Занад дөхөж суугаад ээжийнхээ тухай ярина. Хүдэр чийрэг биетэй, нэг зориглон хөдөлсөн юмандaa амиа ч өгөхөөс буцдаггүй түргэн зантай цайлган сэтгэлт энэхүү зоригт эр, ээжийгээ хүүхэд адил санаж байдгийг мэдээд Занын хамар шархирч, золтой л нулимс унагасангүй...

Өөрөө ч гэсэн нутаг орон, аав ээжээ бодов. Багын танил уул ус нь сэтгэлийн гүнд цэнхэртэн сүүмэлзэж, төрсөн гэрийнх нь аргалын утаа суунаглан, ээж нь гаднаа хүүгийнхээ явсан зүгт сацал өргөн саравчилж байгаа нь дүрслэгдэнэ.

Яагаад ч юм бэ? Занад гэнэт амьд л үлдэх юм сан гэх бодол урьд өмнө байгаагүй хүчтэйгээр орж ирээд байв. Урьд нь энэ тухай төдий л боддоггүй байснаа одоо яагаад ийн шаргуу бодол тархиа хүчлэн шаардах болсны учрыг тэр бээр үл ойлгоно. Энэ нь гагцхүү хүсэл хясал хоёр буй заа! Ховор живэр юманд хүн сониучирхан дурлах бөгөөд мөнөөхөн юм нь элбэг дэлбэг аваас ер санаанд ордоггүйтэй энэ бүхэн үлгэр нэгэн мэт!

Зүүдний юм шиг алсын холоос униартан үлгэрийн шидэт цэнхэр шилэн бүмбад хийсэн эрдэнэсийн зүйл мэт хэтэрхий жавхлан төгс үзэгдэгч хан богд уулынхаа барааг нэг харах сан гэж бодлоо.

Тэхийн сацуу зандан хөлгөнд өрсөн зааны ясан шатар мэт ярайн харагдагч «Баатар» хотын бараа сур сэтгэлд зурагдан, тэнд алхаж явсан аз жаргалтай ахуй үеэ дурсан санав.

Дунд голын улаан гүүрээр Мижидтэйгээ хамт гарч хилэн торго шиг ногоон зулгэн дээгүүр нь алхаж явахад хэчинээн зөөлхөн байсан нь одоо мэдрэгдэх шиг болоод гутлаа дэмий л илж үзэв.

... Тэгээд тэд хоёулаа хөгжмийн хоёр утас шиг бүдүүн нарийн хоолойгоор,

*«Дунд голын ногоо нь
Ургасан байтлаа тарьсан юм шиг
Дунжидмаагийн бүсгүй нь
Төрсөн байтлаа зурсан юм шиг»*

гэж дуулж байснаа санана!

Энэ дууг дуулахад яагаад ч юм бэ Занын сэтгэл хөдөлж, нэгэн үеийн нэгэн хүний амьдралын уяруун түүх санаанд нь ордог ажээ.

... Нөхөд минь хөдлөх цаг боллоо! гэсэн Доржиевын дуугаар бүх хүмүүс биеэ цэгцлэн босоцгоож өөд өөдөөсөө харав.

Эргэн тойрон үдэш болж байх ажээ. Тэнгэр бүрхэж, агаар хүндрэн цас орох төлөвтэй, нэг л бүгчим бүүдгэр оргино.

Энхрий хүүхэд мэт мөрнөөсөө огт мулталдаггүй радио станцаа Нина эвдэлж эхлэхдээ сэтгэл нь түвшэхгүй байгаа бололтой амандаа юм үглэж байлаа. Түүнийг нь анзаарч сонссон ч хүн алга!

Гэвч хэн нэг нь түүнийг тааварлахад төвөггүй байсан юм.

— Одоо шийдвэрлэх цаг боллоо. Өөрийн хань дагуул болсон байлдааны нөхөр чамайгаа би дайсны олз болгохгүй гэж шивнэн шившин байгааг нь, анзаарсан хүн бол амархан мэдэрч болох байлаа. Алексей Петрович, Дмитрий Иванович нар талхны үлдэгдлийг үйрүүлэн төрөлх газар дээрээ цацаж харагдана. Цөмөөрөө тэврэлдэн үнсэлцлээ!

Занын сэтгэл ихэд хөдөлж аливаа түргэн зант хүмүүсийн адилаар түрүүчийн бодлоосоо хэдийн өөр бодолд шилжиж, их хэргийн төлөө эрс шийдсэн нөхдийнхөө агаараар хэдийн амьсгалаад зүрх нь агсам хөөрүү мориных шиг булгилан цохиlj царайд нь хатан зориг тодорч байлаа.

... Цас малгайлан орж эхэллээ. Гэрлийн цагаан эрвээхэй мэт туйлаадас нүдний өмнүүр эрээлжлэн эргэлдэж цас лавсана. Хүн бүр өөрийн очих чиглэлийн дагуу туйлын шаргуу мөлхөж эхэллээ.

Доржиевын заасан чигийг барин өргөст торон хашааны зүг ойртоj яваа Занын нүдэнд Халтархүү тэр хоёр, хашааны цаагуур тойрон зэвсэгт манаанд аймшиггүйгээр дөхөн очих нь харагдана.

Зана ойртоj тусмаа ихэд болгоомжтой мөлхөнө.

Германчууд бруно хэмээх цахилгаант мушгиа утас шатрын маягаар байрлуулан тавьсан нь маш аюултай байдгийг тэр урьдах туршлагаас мэдэх ажээ.

Бас дүгрэг мина, өөрөө тэслэх бөмбөг тэргүүтнийг өвсөнд нуусан байж магад хэмээн сэрэмжилнэ. Тийн явсаар төмөр торыг Иван Васильевичийн хамт таслан эсэн мэнд шургаж өнгөрөөд хашааны доторх давхарлан хураасан авдартай зэвсгийн дэргэд тулан очлоо.

Эргэн тойрон нам гүмийн дунд тэсрэх бодисоо чөлөөтэй шургуулан тавьж байхад нэг л сонин, тайвшрах мэт санагдана.

Нина гэнэт тэнгэрээс унасан мэт тэдэн дээр хүрч ирэв.

— Биднийг эргэн тойрон бүсэлжээ. Яаравчлан тэслэлт хий! гэсэн даргын тушаалыг дамжуулья! гэлээ.

Энэ үгийг сонсоход саяхны байдалтай нэг л дүйж өгөхгүй санагдана.

Гэвч энэ бүгдийг эргэцүүлэх зав алга!

Нинаг хараад украин нутгийн эрэлхэг зоригт тэр бүсгүй гангаар цутгасан хөшөө мэт сүрлэг үзэгдэнэ.

Зана шийдмэг байдлаар захын нэгэн зэвсгийн дэргэд очоод хайрцгийн таг дээр байрлуулсан жижигхэн бараан зүйлийг дарж орхилоо. Нүдэнд нь гэрэл цацрах шиг болоод хамаг бие нь доргиж эгшин зуур нисэж яваа мэт сэтгэгдээд цааш нь юу бодсоныг ч мэдсэнгүй.

* * *

Үүр бүдэг бадаг цайлаа! Өнгөрсөн шөнийн аймшигт явдлын ул мөрийг хучин хааж байсан шөнийн харанхуй аажмаар замхран замхраад, байгаль дэлхий хараа орох мэт орчны юмс тодорч байна.

Түүнчлэн ухаан балартсан нэгэн цогцос сэргж хар үүлээр бүрхэгдсэн нүдний аньсага энэхүү үүрийн гэгээтэй уралдах лугаа нэгэн адил аажим аажмаар нээгдлээ. Нээсэн даруйд газар дэлхий дайвалзан бүрэлзэх шиг болоод дахин нүдээ анив. Тэгэвч удалгүй нээгдлээ.

Зана ухаан орсон даруйдаа орчноо ийнхүү үл мэдэг мэдэрч, амьд үлджээ! гэх бодол цахилгаан мэт гялс хийв.

Тэгэвч удалгүй тэр баясталан үгүй болов.

Үүрд газартай хадагдсан мэт өөрт нь сэтгэгдэнэ. Хөдөлшгүй хөшүүн хүнд юмаар хамаг биеийг нь агдлан даржээ. Оролдоор байж өрөөсөн гарaa суллан авлаа. Осолгүй тархи толгой бүтэн өрөөсөн гар хэвээр үлджээ, гэдгээ мэдмэгц түүнд амьдралын төлөө арсалдан тэмцэх шинэ хүч хуралдсан мэт боллоо.

Атга атгаар шороо авч хаясаар, чимхээр биеэ хөдөлгөсөөр нүсэр шороо тоосноос сугаран гарах үест, ид дүрэлзэж байгаа дайны цусанд будагдсан мэт улайрсан наран тэнгэрийн зүүн хаяанд цухалзаж байв.

Бүхий бие хөндүүрлэхээс гадна зүүн хөл нь тэсгэлгүй бэрх өвчилж, ясандаа янгинан үе үе дуу алдуулна.

За би ч ингээд няцлуулсан ялаа шиг биеэ чирсэн юм амьтай голтой үлддэг байж!

Нөхөд минь юу болоо бол? хэмээн сэтгээд ийш тийш дэмий л сэргээлзэн харна. Зэвсгийн сэг, утаа хүхрийн эхүүн үнэр, цус шороо хутгалдан үзэгдэнэ! Арай ядан мөлхсөөр Нинагийн байсан газар хүрвэл, энэ ертөнц дээр тийм хүн байсан гэхийн тэмдэггүй болоод ойролцоо нэгэн ёрдгор төмөрт орооцолдсон цустай алчуурын өөдөс, тэр хүнээс би л үлдлээ дээ гэсэн шиг салхинд сэргээлзэж байлаа.

Нүдээр нь цийлэлзэн бүрхсэн нулимсанд ямар нэгэн хар юмс босож байгаа мэт үзэгдэхэд дэмий л нулимсаа арчина.

Нөхдөөс нь хэн ч үлдсэнгүй. Гар хөлийн тасархай, цус шороонд хутгалдсан энэхүү аймшигийг дайн өөрийнхөө цуст гараар гурил шиг зуураад түүний өмнө тавьсан ажээ.

Орчлон дээр энэ мөчид хамгийн их ганцаардаж байгаагаа тэр мэдэрч нөхдийнхөө нэrsийг амандаа шивнэн нулимс асгаруулав.

Мөлхөх бүр зүүн хөл нь голыг нь сугалах адил янгинан өвдөж чангаана. Ямар ч л гэсэн тэр дайсан тулгарвал эцсээ хүртэл эрслэн тэнцэж нөхдийнхөө өшөөг авах хэрэгтэй болсноо ухаарав.

Үүр цайгаад өдөр болж эхэлснийг мэдмэгц сэтгэл дотроо нөхөдтэйгөө салах ёс гүйцэтгээд бартаанд орохоор хөлөө чирэн мөлхөж эхэллээ! Ойд ормогц цас үмхлэв. Эхлээд дотор сэргүү оргих шиг аятайхан байснаа сүүлдээ ам нь заваарахад идэхээ болив.

Цааш яаравчлан мөлхөж зарим уруу газар хуйлаастай эсгий шиг өнхөрч хүртэл явсаар гүн ойд шургалаа.

Зад цохигдсон гутлаа ноцолдоор байж арайхийж тайллаа. Ясан шилбэ нь няцарч хугараад гоожсон цус нь зарим газраа наалдан хатжээ.

Суран тэлээгээ зүсэж хугарсан хөлдөө мод чиг барьж бооход арай дээрдсэн боловч саяхан хөндсөн шарх нь янгинан дуу алдуулж байлаа.

Эргэн тойрон Шишкины зураг мэт ой үргэлжилжээ! Энэ их ойн хаана нь нөхөр, хаана нь дайсан байгааг урьдаас яахин мэднэ! гэхийн дээр гартаа зэвсэггүй, шархтай хөлтэй хэрхэн амьд гарах билээ хэмээн эргэцүүлнэ! Бодох бүр боломжгүй хариу гарна. Гэвч түүнд амьд үлдэж зорьсондоо хүрэх, нөхдийнхөө өшөөг авах нь чухал учир олныг бодолгүй ойд улмаар нэвтрэн цаашилж эхэллээ.

Цасан дээр түүний мөр сарзгар хэв үлдээж цаашлан цаашилсаар хөвчийн гүнд далран шургажээ.

4 ДҮГЭЭР БҮЛЭГ

Зана хүнд дуудуулсан юм шиг гэнэт нойрноос сэргээ. Ханын цагийг хяламхийж хармагц — ажлаас хожимдох нь хэмээн амандаа углээд өндийн завдсанаа буцаж ороо тохойлдон тамхиа асаалаа. Учир нь өнөөдөр бүтэн сайн өдөр гэдгийг санажээ.

Ханан дахь он тооллын хуудас 1966 оны 5 дугаар сарын 8-ны ням гаригийг зааж байх ажээ.

Хорин таван жил! гэж тэр сэтгэлдээ тооцоолоод түүнээ батлах гэсэн мэт.

— Тийм ээ, тэр цагаас хойш хорин таван жил өнгөрч! гэж ганцаараа давтан ярив.

1941 оны тэр нэгэн өглөө Зана ийнхүү гэнэт сэrsнээ санажээ. Тэхэд түүний байрласан буудлын цонхоор Москвагийн олон давхар барилгын сурлэг орой ярайж, түгшүүрт хөл шуугиан чих дэлсэж байсан бол эдүгээ хан бодын хяр дүнхийж, хатан Туулын хөвөөнд орших ажилчдын сууцын өглөө эхэлж үүдний хонгилоор эртэч жаалууд гүйлдэн, эхийнх нь хааяа зандрах, дорхноо аргадах дуу сонстох аж.

— Хүний амьдрал бас сонин оо! гэж Зана хувцаслаж дуусаад цайлж суухдаа бодлоо.

Хүү охин хоёр нь эртэлж босоод цайг нь чанаж охин нь бодвол зэргэлдээ айлын үетэнтэйгээ ярьж суугааг тааварлана.

Хүүгийнх нь номын сумкны булан ханзарч цүү цуурга нь эвдэрснийг зэрвэсхэн харах зуураа,

— Бидний л хийж байгаа ажил шүү дээ! Бас л сайн болж чадахгүй байна уу даа! Гутлын уллагааны тухай амьтны гомдол энэ жилээс арай гайгүй болоо юу даа! гэж бодохын зэрэгцээгээр нөгөөх түүхтэй «Дайчин гутал нь» санаанд нь орж ирэв.

Тэгээд гашуунаар инээмсэглэж, тэр цагийг дурсан бодлоо.

Хоёр хоногийн турш ямар тэсвэр гарган, яаж мөлхөж чадсанаа бодох бүрдээ гайхааш төрөх шиг болоод, хүн ер нь зовлон даадаг, жаргал даадаггүй амьтан даг шүү гэсэн дүгнэлт хийгээд аягатай цайгаа нэг том очлоо.

Тэгээд тагнуулд явсан цэргүүдтэй золоор тааралдаж улаан цэргийн эмнэлэгт хүргэгдэн, улмаар Улаан-Үдэ хотод 6 сар сувилуулж

Эдгэрсэн хийгээд түүний гутлаас «Тамсаг булаг дахь 6 дугаар дивизийн 1 дүгээр хорооны пулемёт сумангийн дарга Гончигийн Зана» гэсэн үнэмлэхийг нь олж үзээд, монгол хүн байна гэж эмнэлгийнхэн хөл хөөр болж байсныг нь дэс дараалан санаадаа,

— Тийм ээ би ч тэр цагт Дандар баатрын цэрэг явсан хүн юм шүү дээ гэж сэтгэлдээ өгүүлэхэд нь тэрхүү үнэмлэхийнх нь дор татлангуй зурсан хороон даргынх нь гарын үсэг, түүний цаанаас ширүүн халимагтай хөхөвтөр өнгөт зоримог царай нь харагдах шиг болов.

Сэтгэл нь хөдөлсөн үедээ сав л хийвэл авч үздэг, «Өдөржин, Шөнөжин» гэдэг номын завсраасаа хацрынхаа доохноо хар мэнгэтэй, сагсгардуу урт үсээ украин маягаар засаж самнасан хорь эргэм насны цэнхэр нүдэн бүсгүйн зургийг гаргаж Нина гэж шивнэв.

— Ямар нэгэн зөнгөөр түүний амьд үлдэхийг таасан ч юм билүү, зүгээр тийм тохиолоор ч юм уу? сүүлчийн тэр салалтын орой Нина түүнд энэ зургаа бэлэглэсэн юм байжээ.

Нинагийн зургаас уламжлан эх орны дайны шуурган жилүүдэд мөр зэрэгцэн байлдаж явсан сайн нөхдөө дурслаа.

Сэтгэл нь ихэд хөдлөн хоолны шүүгээгээ нээж галуун хүзүүтийн ёроолд үлдсэн гашуун дарснаас хундагалж уучхаад улам ч уяран урьдах бодлоо үргэлжлүүллээ!

... Жаран хоёр онд би хэрэг болгож амралтаараа Завхан аймгийн Цэцэн уул sumaар явж билээ. Тэгээд нэг айлд ороход яах аргагүй Халтархүүгийн минь зураг нүдэнд тусч би дуу алдаад нэг мэдэх нь ээ толь жаазны нь өмнө хүрчихсэн сууж байлаа.

Туранхай цагаан хөгшин бас л над шиг дуу алдан,

— Хүү минь чи миний хүүг таньдаг байсан юм уу? гэж асуугаад үй зайгүй үерхэж явсныг минь мэдмэгц насан туршдаа ямар ч шүтээнээсээ илүү нандигнан хадгалдаг захидалдуудаас нь үзүүлж билээ!

... Хүү чинь энэ зуныхаа амралтаар ээж тандаа очиж золгож чадахгүй нь ээ! Өөрийн саналаар улаан армид туслахаар явж байна. Манай тэнд ч ялгаагүй фронтод туслах ажил явагдаж байгаа биз дээ. Дайснаа дарж дархан цолоо олоод та нартайгаа баяр хөөрөөр уулзан золгоно.

Дараа дэлгэрэнгүй захидал бичье!

Галт тэрэг хариутгүй хөдлөх гээд байна. Хайрт ээж минь сайн сууж байгаарай 1941-7-р сарын 6.

Москва гэсэн үг тодроход өөрийн эрхгүй нүдэнд манан бүрхэж, тэр манан дундаас Халтархүүгийн минь дүр тодрон байсан сан.

Галт тэрэг хөдлөхийн өмнөхөн Доржиевт үүргэвчээ орхиод Халтар маань яаран шуудан руу гүйж байсан нь энэ байжээ гэж бodoход захидалыг нь элгэндээ наагаад суумаар санагдсан сан.


... За тийм. Дайн гэж ямаршуу хатуу тоглоом болохыг нь би биеэрээ үзсэн хүн шүү! Өнөөдрийн энэ сайхан цаг чинь ийм л өндөр үнээр олдсон юм! гэж сэтгэлдээ яриад Зана ахин нэг хундага суллахад,

— Та чинь ингэхэд яаж л байна даа гэсэн шиг аж үйлдвэрийн комбинатын гутлын үйлдвэрийн тэргүүний ажилчин 60 настай өвгөн Занын зураг жааз дотроос зэмлэх мэт ширтэж байлаа.

ТӨГСӨВ

1967-8-17.
Улаанбаатар.

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу орно уу.



Өглөгийн эзний сонорт

×

Та манай номын санд хандив өргөж болно.

Таны хандивласан мөнгө:

- Хэвлэгдсэн номыг цахим хэлбэрт оруулах
- Цахимд оруулсан номыг ариутган шүүх
- Цахим технологийн тоног төхөөрөмж авах
- Цахим номын санг өргөжүүлэх
- Цахим номын сангийн чиглэлээр судалгаа хийж, сурч байгаа оюутан судлаачийг дэмжихэд зарцуулагдана.

Хандив өргөх данс "Хаан банк" 5027 8982 35 (төгрөг) ЦОГТ ОХИН ТЭНГЭР САН

Qpay

1968 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл

Ш. Сүрэнжав

УУЛЫН САЛХИ

Зургийн редактор В. Одгийв

Техник редактор Ц. Содов

Хянаагч З. Сагар, Ц. Энхээ

*Өрөлтөд 1968 оны 4 дүгээр сарын 9-нд орж,
Хэвлэлтэд 1968 оны 5-р сарын 1-нд шилжүүлжс
6000 ширхэг хэвлэв.*

Цаасны хэмжээ 70×108

A-36207 Хэв. Хуудас 2, 25 XHX 3, 08 Т. Х 2, 8

СХ-ийн УБТЗ-ын хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Наушки-Улаанбаатарын гудамж, байшин №26

Заметки

[←1]

Д. Лодоншаравын хамт.